



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6

- Аудитын тухай Монгол Улсын хууль
- Нотариатын тухай Монгол Улсын хууль
- Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

1997 ОН



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 6-р сар №6 /61/

## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |   |     |
|---|-----|
| 1. Үндсэн хуулийн цэцэг маргаан хянан шийдвэрлэх ажллагааны тухай   | 509 |
| 2. Аудитын тухай  | 526 |
| 3. Нотариатын тухай   | 540 |
| 4. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай   | 553 |
| 5. Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай  | 554 |
| 6. Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай   | 555 |
| 7. Зарлиг, хуулийн заалт хүчингүй болсонд тооцох тухай  | 556 |
| 8. Зарим бараанд ногдуулах экспортын гaalийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  | 556 |
| 9. Нягтлан бодох бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай   | 557 |
| 0. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай   | 558 |
| 1. Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай   | 558 |
| 2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл заалт, хүчингүй болсонд тооцох тухай, Хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 559 |
| 3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай   | 560 |
| 4. Зарим бараанд ногдуулах экспортын гaalийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай  | 560 |

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |  |     |
|--|-----|
| 5. Үндсэн хуулийн цэцгийн дүгнэлтийн тухай №28                                 | 562 |
| 6. Тогтоолын төсөл буцах тухай №30   | 563 |
| 7. Монгол Улсын Их Хурлын 1993 оны 59 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай №31 | 563 |

18.	Үндсэн хуулийн цэцийн гишүүний өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг батлах тухай №32	564
19.	Хуулийн төсөл буцаах тухай №33	566
20.	Хуулийн төсөл буцаах тухай №34	566
21.	Хуулийн төсөл буцаах тухай №35	567
22.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийг товллох тухай №36	568
23.	Тогтоолын төсөл буцаах тухай №37	568

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

24.	БНПУ-ын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай №65	569
25.	Н.Өлзийд Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №74	569
26.	Х.Шаравт Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгох тухай №75	570
27.	Сайто Жоро, Сүлүхи Мүнээ, Цунээ Икэда нарыг одон, медалиар шагнах тухай №76	570
28.	Комисс томилох тухай №77	571
29.	Б.Ширэндэвт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай №78	572
30.	Ш.Пүрэвжавт Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №79	572
31.	Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх тухай №81	573
32.	Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай №82	574
33.	Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай №83	574
34.	Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дүрмийг батлах тухай №111	575

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарны 1-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх  
ажиллагааны үндсэн журам

#### 1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршино.

#### 2 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомж

Үндсэн хуулийн цэцэд /цаашид "Цэц" гэх/ маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хуулиас бүрдэнэ.

#### 3 дугаар зүйл. Маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүн

1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хуулиар тогтоосон журмын дагуу томилогдсон Цэцийн гишүүд хэрэгжүүлнэ.

2. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бага суудал 3, дунд суудал 5, их суудал 7-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

3. Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг үндэслэн маргаан үүсгэх эсэх талаар Цэцийн гишүүний шийдвэрийн талаар гарсан гомдлыг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй; Цэцийн хуралдаанд оруулахаар маргаан үүсгэн шалгасан бүх асуудлыг анхлан шийдвэрлэх хуралдааныг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй; Цэцийн хуралдаанаас гаргасан дүгнэлтийг Улсын Их Хурал

4.Тухайн хуралдаанаар маргааныг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл, байдал үүсвэл уг нөхцөл, байдлыг арилгах боломжтой хугацаагаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулна.

5.Цэцийн хуралдааныг Цэцийн гивүүн солигдсон шалтгаанаар хойшлуулсан бол хуралдааныг эхнээс нь шинээр явуулна. Хуралдаан бусад оролцогчид өөрчлөгдсөн нь Цэцийн хуралдааныг хойшлуулсан үе шатнаас үргэлжлүүлэн явуулахад саад болохгүй.

#### 9 дүгээр зүйл. Мэтгэлцэх

1.Цэцийн хуралдаанд маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгчид маргаж байгаа асуудлаар харилцан бие биедээ асуулт тавьж, хариулт авах, гомдлын шаардлага, татгалзаллын үндэслэл болсон нотлох баримтуудыг харилцан няцаах, энэ талаархи баримтуудыг зохих журмын дагуу гаргах, батлах зэргээр мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлнэ.

2.Цэц маргагч талуудад чөлөөтэй мэтгэлцэх бололцоо олгоно.

#### 10 дугаар зүйл. Цэц нууц зөвлөлдөх

1.Цэцийн шийдвэр гаргах гивүүдийн зөвлөлдөөнийг тусгай тасалгаанд хийнэ.

2.Цэцийн зөвлөлдөөн хийж байгаа тасалгаанд хуралдааны бүрэлдэхүүнд орсон гишүүд, зөвлөлдөөний тэмдэглэл хөтлөх хуралдааны нарийн бичгийн даргаас өөр хүн орохыг хориглоно. Зөвлөлдөх тасалгаанд гишүүдийн гаргасан саналыг задруулахыг хориглоно.

#### 11 дүгээр зүйл. Цэцийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх

1.Цэц шийдвэрээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргана.

2.Цэцийн шийдвэр нь Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон энэ хуулийн холбогдох заалтын үг үсэг, утга санаанд бүрэн нийцсэн нөхцөл, хууль ёсны болно.

Цэц болон Цэцийн гивүүн Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн заалттай харшлаагүй бусад хуулийн заалтыг удирдлага болгож болно.

3.Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлуудыг хуралдааны үед бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, гарах дүгнэлтийг нотлох баримтуудаар хангалттай баталсан нөхцөл Цэцийн шийдвэр үндэслэлтэй болно.

4.Цэцийн эцсийн шийдвэр нь гармагц хүчин төгөлдөр болно.

**12 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа хараат бус байх**

1. Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж аягаа Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, бусад иргэнээс хараат бус байж, гагцхүү идсэн хуульд захирагдан, дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэнэ.

2. Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэхдээ аль нэг гээдийг төлөөлөхгүй.

3. Албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнээс маргаан хянан шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэхэд эндлөнгөөс оролцох, шахалт дарамт үзүүлэх, бусад элбэрээр нөлөөлөхийг хориглоно.

4. Цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааныг мэдээлэл саналаа урьдчилан хэлэх, энэ талаар бусдад эвлөгөө өгөх эрхгүй.

**13 дугаар зүйл. Маргааныг харьяалал**

1. Цэц Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай дор дурдсан маргааныг хянаж дүгнэлт гаргах бөгөөд мэдээлэлтэй бол дахин хянаж, эцэслэн шийдвэрлэнэ:

1/хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр;

2/Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, бусад шийдвэр;

3/Засгийн газрын шийдвэр;

4/Монгол Улсын олон улсын гэрээ;

5/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийн татаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр.

2. Цэц дор дурдсан албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргана:

1/Монгол Улсын Ерөнхийлөгч;

2/Улсын Их Хурлын дарга;

3/Улсын Их Хурлын гишүүн;

4/Ерөнхий сайд;

5/Засгийн газрын гишүүн;

6/Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч;

7/Улсын ерөнхий прокурор.

3. Цэц дор дурдсан албан тушаалтнуудыг огцруулах болон эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана:

1/Монгол Улсын Ерөнхийлөгч;

2/Улсын Их Хурлын дарга;

3/Ерөнхий сайд;

4/Улсын Их Хурлын гишүүн.

4.Цэцэд ирүүлсэн маргааны шаардлагын зарим нь Цэцэд, зарим нь өөр шүүх буюу бусад байгууллагад харьяалалтай байвал Цэц зөвхөн өөрийн харьяалалтай маргааны шаардлагыг шийдвэрлээд бусдын харьяалах маргааны шаардлагыг шийдвэрлэхээс татгалзана. Энэ нь төр маргааныг харьяалах байгууллагаас хянах шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүй.

14 дүгээр зүйл. Хэргийн харьяалал тогтоох

Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллагыг Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.

15 дугаар зүйл. Цэцэд маргаан хянах шийдвэрлэх ажиллагааны хүрээ

1.Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянах шийдвэрлэнэ.

2.Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй.

3.Цэц маргаан хянах шийдвэрлэх ажиллагааг зөвхөн өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр үүсгэн явуулна.

Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсо хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянах шийдвэрлэж болно.

4.Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр бол үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хой гарсан хууль тогтоомж болон албан тушаалтын үй ажиллагаатай холбогдсон маргааныг хянах шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах

1.Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл мэдээллийг иргэд; хүсэлтийг Ерөнхийлөгч, Улсын И Хурал, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхи прокурор гаргах эрхтэй.

2.Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах эрхийг Монгол Улсын иргэдээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэр хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн харьяалалгүй хүн эдэлнэ.

17 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч

1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь:

1/Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үсгэх өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан иргэд, эрх бүхий албан тушаалтан, байгууллага, түүнчлэн илдсэн хууль зөрчсөн гэж маргаан үүсгэсэн хууль, зусад шийдвэрийг гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан байгууллага, албан тушаалтан;

2/албан тушаалын байцлаар буку зохих журмын дагуу томилогдсон итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгч байна.

2. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох итгэмжилсэн төлөөлөгч нь Иргэний хэрэг үүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу томилогдсон байна.

18 дугаар зүйл. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг

1. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь тус тусын бүрэн эрхийн хүрээнд адил эгш эрх эдэлнэ.

2. Маргагч талууд Цэцэд хянаж байгаа маргааны материалтай танилцах, холбогдох бичиг баримтыг уулбарлан авах, тэмдэглэл хийх, нотлох баримтыг аргаж өгөх, нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд оролцох, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад арсан бүх асуудлын талаар өөрийн санал, дүгнэлтийг аргах, маргаан хянан шийдвэрлэх хуралдаанд чөлөөтэй мэтгэлцэх, шаардлагатай гэж үзэж байгаа бол өгсгөлийн үг хэлэх, хүсэлт тавих эрхтэй.

3. Оролцогч талууд Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнээс татгалзан гаргах саналыг хуульд заасан үндэслэлийн дагуу тавих эрхтэй.

4. Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал янаж байгаа асуудлын хүрээнд Цэцийн хуралдаан өвлөлдөхөөр завсарлахаас өмнө аль ч шатанд өөрийн аардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буку арим хэсгээс нь татгалзах эрхтэй.

5. Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцож байгаа аргач талууд өөрсдийн шаардлагын үндэслэл болон өрөг шаардлагыг эсэргүүцэж байгаа үндэслэлээ батлах бичиг баримтыг бүрдүүлж, нөхцөл байдлыг нотлох үрэгтэй.

6.Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч Цэцийн хуралдаанм дэгийг чанд сахих, хуралдаан даргалагчид захирагдах үүрэгтэй.

7.Маргаан хянан шалгах ажиллагаанд оролцогч Цэцийн хуралдаанм дэгийг дахин зөрчих, Цэц болон түүний гишүүдэд хуурамч бичиг баримт өгвөл Цэцийн хүндэтгээгүй үйлдэл гэж үзэж зохих хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**19 дүгээр зүйл.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанм зардал**

1.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанм оролцсон гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчийн болон бусад шаардлагатай зардлыг улсын төсвөөс төлнө.

2.Цэцэд маргаан хянан шалгах ажиллагааг үүсгэх үндэслэл болсон өргөдөл, мэдээлэл гаргасан иргэн орон нутагт оршин суудаг бол түүнийг Цэцийн хуралдаанд оролцсонтой холбогдсон зардлыг:

1/уг иргэний өргөдөл, мэдээлэл үндэслэлтэй гэж тогтоогдсон бол Үндсэн хууль зөрчсөн хууль, зарлиг, бусад шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан буюу Үндсэн хууль зөрчсөн албан тушаалтан;

2/хэрэв өргөдөл, мэдээлэл нь үндэсгүй бол тогтоогдсон бол уг иргэн өөрөө хариуцна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх, хуралдаанд бэлтгэх**

**20 дугаар зүйл.Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах**

1.Иргэн, байгууллага, албан тушаалтан Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

1/өөрийн нэр, хаяг, оршин суугаа газар, харилцаа хэлбэр;

2/түүний итгэмжилсэн төлөөлөгч буюу өмгөөлөгчөө оролцох хүний нэр, хаяг, албан тушаал, бусад шаардлагатай мэдээлэл;

3/Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомжийн нэр, батлан гаргасан он, сар, өдөр дугаар, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа албан тушаалтны нэр, хаяг үйл ажиллагаан талаар;

4/өөрийн шаардлагын үндэслэл, бусад нөхцөл айдлал, тэдгээрийн нотолгоо;

5/маргаж байгаа асуудлын талаархи өөрийн байр уурь;

6/Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлага;

7/Үндсэн хууль болон энэ хуулийн ямар зүйл, эсэг, заалтыг үндэслэн Цэцэд хандаж байгаа;

8/хавсаргасан бичиг баримт болон холбогдох үмүүсийн нэрсийн жагсаалт, тодорхой хаяг.

2.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өргөдөл, эдээлэл, хүсэлт гаргасан этгээдийн итгэмжилсэн өлөөлөгч оролцох бол итгэмжлэл, түүнчлэн монгол элээс өөр хэл дээрх бичиг баримт хавсаргаж байгаа ол түүний орчуулгыг заавал хавсаргана.

3.Цэц нэргүй өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээж вахгүй.

21 дүгээр зүйл.Цэцэд өргөдөл, мэдээлэл хүсэлтийг хүлээн авах

1.Иргэн, байгууллага, албан тушаалтнаас Цэцэд аргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн дарга г асуудлыг хянан шалгах гизүүнд хуваарилна.

2.Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гизүүн анхны алгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх ээхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.

3.Цэцэд хандах эрх бүхий байгууллага, албан ушаалтнаас гаргасан хүсэлтийг хүлээн авсан Цэцийн ишүүн маргаан шууд үүсгэж шалгана.

4.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх ээх талаархи Цэцийн гизүүний шийдвэрийг маргагч алууд буюу Цэцийн аль нэг гизүүн эс зөвшөөрч эмдол, санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын эгтоолоор томилсон 3 гизүүний бүрэлдэхүүнтэй үралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэр-эх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал аргана.

5.Цэцийн гизүүн иргэнээс гаргасан өргөдөл, эдээллийг урьдчилан шалгаж дор дурдсан үндэслэл ийвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс итгалзаж тогтоол гаргана:

1/өргөдөл, мэдээлэл нь энэ хуулийн 20 дугаар йлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

2/өргөдөл, мэдээлэл гаргагч нь Цэцэд хандах эрх /хий этгээд биз;

3/өргөдөл, мэдээллээр тавьсан шаардлага Цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан бий;

4/уг маргааны талаар Цэцийн урьд гаргасан дүгнэлт, тогтоол хүчинтэй байгаа.

22 дугаар зүйл. Цэцийн гишүүн татгалзан гарах

1. Цэцийн гишүүнийг энэ хуульд зааснаас өөр үндэслэлээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргаж үл болно.

2. Цэцийн гишүүн дараахь үндэслэл байвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарна:

1/хянан хэлэлцэж байгаа хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээг батлан гаргахад таслах эрхтэйгээр оролцсон;

2/хянан хэлэлцэж байгаа асуудлыг урьд өмнө шүүхийн болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож байсан;

3/маргагч талууд буюу тэдгээрийн төлөөлөгчидтэй ойрын төрөл садан бол.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байвал Цэцийн гишүүн энэ тухай өөрөө мэдэгдэж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй. Маргагч талууд дээрх үндэслэлээр Цэцийн гишүүнийг татгалзан гаргах хүсэлт тавих эрхтэй.

4. Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах асуудлыг Цэцийн хаалттай хуралдаанаар хэлэлцэж магадлал гаргана.

5. Маргааныг шалгасан Цэцийн гишүүн татгалзан гарвал уг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг шинээр эхэлнэ.

Цэцийн хуралдаанд оролцсон Цэцийн бусад гишүүдээс татгалзан гарвал хуралдааныг эхнээс нь явуулна.

23 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд бэлтгэх

1. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаа гишүүн уг маргааныг Цэцийн хуралдаанд хэлэлцүүлэхээр дараахь ажиллагааг хийнэ:

1/маргагч талуудад өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлын, хуулбарыг гардуулж, маргаанд оролцох итгэмжилсэн төлөөлөгчөө томилох тухай мэдэгдэх;

2/маргагч талуудад энэ хуульд заасан эрх, үүргийг танилцуулж, Цэцэд шинээр нотлох баримт гаргахад нуслах;

3/маргагч талууд болон тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгчийг асууж, тайлбар, тодорхойлолт гаргуулах;

4/маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой бичиг баримт, бусад мэдээллийг шаардан гаргуулах;

5/маргаантай холбогдол бүхий албан тушаалтан бусад хүмүүсийг асууж тодорхойлолт авах;

6/шаардлагатай бол эрдэмтэн, мэргэжилтэн оролцуулах, тусгай мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах, үүгнэлт гаргуулах;

7/гэрчээс тодорхойлолт авах;

8/нэг асуудлаар хоёр бууу хэд хэдэн өргөдөл, эдээлэл, хүсэлт байгаа бол тэдгээрийг нэгтгэх, нэг өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд хоёр бууу хэд хэдэн өр шаардлага тавьсан бол тэдгээрийг тусгаарлах тогтоол гаргах;

9/маргагч талууд харилцан ойлголцож өргөдөл, эдээлэл, хүсэлт гаргасан тал нь шаардлагаасаа сайн ураараа татгалзвал маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг татгалзах тогтоол гаргах;

10/цугларсан бичиг баримтад үндэслэн Цэцийн хуралдааны шийдвэрийн тэмдэглэх, тодорхойлох хэсгийн өслийг бэлтгэх;

11/маргааныг бүрэн гүйцэд, бодитой шийдвэрлэхэд аардагдах бусад бэлтгэл ажиллагаа.

2.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэснээс ойш хуралдаанд бэлтгэх ажиллагааг 30 хоногийн өтср гүйцэтгэх бөгөөд маргаан ээдрээ, төвөгтэй алтгаанаар дээрхи хугацаанд дуусахгүй бол Цэцийн арга 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.Онц болон дайны байдал зарласан, түүнчлэн цэрэг өдөлгөх шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааг 3 хоногийн дотор гүйцэтгэнэ.

4.Онц хүндрэлтэй, яаралтай шийдвэрлэх асуудлыг хянан хэлэлцэх хуралдааны бэлтгэлийг хангахын тулд эцийн даргын тогтоолоор хоёр бууу хэд хэдэн ишүүнийг томилон ажиллуулж болно.

5.Байгууллага, албан тушаалтан, иргэн Цэцийн ишүүний шаардсан бичиг баримтыг хугацаанд нь аргаж өгөх үүрэгтэй.

24 дүгээр зүйл. Цэцийн хуралдааныг зарлах

1.Цэцийн гишүүн маргааныг Цэцийн хуралдаанд элэлцүүлэх бэлтгэл ажиллагааг дууссан гэж үзвэл үүнийг Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх тухай тогтоол гаргана.

2.Цэцийн хуралдааныг нээлттэй хийнэ. Улсыг батлан амгаалах, үндэсний аюулгүй байдал, төрийн болон

байгууллага, хувь хүний хуулиар хамгаалсан нууцтай холбоотой асуудлыг Цэцийн хаалттай хуралдаанаар хэлэлцэх бөгөөд маргааныг Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх тогтоолд энэ тухай заана.

3.Цэцийн гизүүн нь хуралдааныг нээлттэй буюу хаалттай хийх, мөн Цэцийн даргатай зөвшилцөн хуралдаан болох газар, өдөр, цагийг товлож энэ хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд 7 хоногийн өмнө төрийн төв хэвлэлд нийтэлж зарлана.

4.Маргагч талууд, гэрч, шинжээч болон бусад оролцогчдод Цэцийн хуралдаан болох газар, өдөр, цагийг албан ёсоор мэдэгдэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Маргааныг Цэцийн хуралдаанаар хянан шийдвэрлэх

#### 25 дугаар зүйл.Цэцийн хуралдаанд хүндэтгэл үзүүлэх

1.Цэцийн хуралдааныг Монгол Улсын төрийн сүлд, далбааг хүндэтгэлтэй байрлуулсан танхимд хийнэ.

2.Цэцийн бүрэлдэхүүнийг орж ирэхэд танхимд байгаа хүмүүс суудлаасаа босож хүндэтгэнэ.

3.Цэцийн хуралдаанд оролцох гизүүд тусгай өмсгөлтэй байна.

#### 26 дугаар зүйл.Цэцийн хуралдааныг нээх

1.Цэцийн хуралдааныг Цэцийн даргын тогтоолоор томилсон хуралдаан даргалагч, гизүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хийнэ.

2.Хуралдаан эхэнд маргагч талууд болон гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагчдын ирцийн талаар нарийн бичгийн дарга танилцуулна.

3.Хуралдаан даргалагч хуралдааныг нээж, хэлэлцэх асуудлыг зарлана.

4.Хуралдаан даргалагч маргагч талуудад эрх, үүрэг, хариуцлагыг нь тайлбарлан танилцуулна.

5.Хуралдаан даргалагч маргаан хянан шийдвэрлэх Цэцийн бүрэлдэхүүнийг танилцуулна.

6.Маргагч талуудаас гэрч оролцуулах, шинжээч томилуулах, шинээр нотлох баримт гаргах, хуралдааны бүрэлдэхүүнээс гизүүнийг татгалзан гаргах санал байгаа эсэхийг асууж шийдвэрлэнэ.

7.Хуралдаан даргалагч шаардлагатай гэж үзвэл гэрчийг танхимаас гаргана.

8.Хуралдаан даргалагч Цэцийн хуралдааны дараалал, дотоод журмыг танилцуулж маргагч талууд болон танхимд байгаа хүмүүст хуралдаан даргалагчид захирагдах үүрэгтэйг сануулна.

27 дугаар зүйл.Цэцийн хуралдаанд оролцогч тал хүрэлцэн ирээгүйн холбогдол

1.Маргагч тал болон гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч Цэцийн хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол түүний шалтгааныг тодруулна.

2.Маргагч тал хуралдаан болох газар, байр, сар, өдөр, цагийн тухай албан ёсны мэдэгдэл авсан боловч хүндэтгэн үзэх ямар нэгэн шалтгаан заасан саналаа ирүүлээгүй, өөрийн нь эзгүйд асуудлыг шийдвэрлэхийг зөвшөөрснөө бичгээр ирүүлсэн бол хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.Маргагч тал хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирээгүй бөгөөд өөрөө заавал биечлэн оролцох хүсэлтээ албан ёсоор мэдэгдсэн бол хуралдааныг хойшлуулах тухай магадлал гаргаж, түүнд уг хуралдааныг хийх хугацааг заах буюу тийм боломжгүй бол дараа зарлахаар тогтооно.

4.Гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч хүрэлцэн ирээгүй бол хуралдааныг хийх эсэхийг тухай бүр шалтгаан шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл.Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх

1.Цэцийн хуралдаанд маргаан хянан хэлэлцэх ажиллагаа уг маргааныг урьдчилан шалгасан Цэцийн гишүүний илтгэлийг сонссоноор эхэлнэ.

Цэцийн гишүүн илтгэлдээ маргааны гол агуулга, гүүнтэй холбоотой нотлох баримтыг өөрийн урьдчилсан дүгнэлт, саналгүйгээр танилцуулна.

2.Гишүүний илтгэлийг сонссоны дараа хуралдаанд маргагч талуудаас нэмэлт тайлбар байгаа бол өргөцөл, мэдээлэл, хүсэлт гаргасан талаас эхэлж ээлж дараалан сонсоно.

3.Нотлох баримтыг шинжлэн судлах, гэрч, шинжээч, мэргэжилтнүүдийн мэдүүлэг, дүгнэлт сонсох ажиллагаа гвуулах бөгөөд дарааллыг хянан хэлэлцэж байгаа маргаан тус бүрийн онцлогийг харгалзан хуралдаан даргалагч тогтооно.

4.Оролцогч талууд харилцан мэтгэлцэх бөгөөд ээлж дарааллыг хуралдаан даргалагч тогтооно.

5.Цэцийн бүрэлдэхүүнд орсон гишүүд хуралдааны аль ч шатанд хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтөйгээр хэнээс боловч асуулт тавьж, хариулт авах эрхтэй.

6.Бүх нотлох баримтыг шалгаж, мэтгэлцээн, асуулт, хариулт дууссаны дараа маргагч талуудад төгсгөлийн үг хэлж, хүсэлт гаргах санал байгаа бол сонсоно. Дараа нь шийдвэр гаргахаар Цэцийн хуралдаан завсарлаж байгааг хуралдаан даргалагч зарлана.

7.Цэцийн хуралдааны явцад маргааныг нэгтгэх, тусгаарлах асуудал гарвал, энэ тухай магадлал гаргана.

**29 дүгээр зүйл.Цэц шийдвэр гаргахаар зөвлөлдөх**

1.Цэц шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана. Цэцийн шийдвэрийг хуралдаанд оролцсон аль нэг гишүүн бичнэ.

2.Зөвлөлдөх тасалгаанд асуудал шийдвэрлэхэд Цэцийн хуралдаанд оролцсон гишүүн бүр адил тэгш эрхтэй бөгөөд тухайн шийдэх гэж байгаа асуудлын талаар өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, тайлбарлах эрхтэй.

3.Цэцийн шийдвэрийг тухайн хуралдаанд оролцсон гишүүд зөвлөлдөх тасалгаанд хаалттай хуралдаанаар хэлэлцэж гаргахдаа уг маргааныг хуралдаанд илтгэсэн гишүүн өөрийн санал, дүгнэлтийг эхэлж гаргах бөгөөд түүний дараа хуралдаанд оролцсон гишүүдийн хамгийн ахмад настай гишүүнээс эхлэн насны эрэмбээр дүгнэлт, саналаа хэлж, хуралдаан даргалагч эцэст нь саналаа гаргана.

4.Цэцийн хуралдаанд оролцсон гишүүн зөвлөлдөх тасалгаанд асуудал шийдвэрлэхэд саналаа заавал өгнө.

5.Цэц зөвлөлдөх тасалгаанд шийдвэрээ гаргасна дараа хуралдаан даргалагч болон бусад гишүүд бүгд гарын үсэг зурж, хуралдаан даргалагч буюу түүний даалгаснаар аль нэг гишүүн нийтэд уншиж сонсоно.

6.Цэцийн хуралдаанд оролцсон гишүүдийн санал тэнцсэн, маргааны талаар нэмэлт шалгалт хийх шаардлагатай болсон бол Цэц уг маргааныг 30 хоногийн дотор дахин хянан хэлэлцэж шийдвэрлэхээр хойшлуулж, энэ тухай магадлал гаргана.

**30 дугаар зүйл.Маргааныг дахин хянан шийдвэрлэх**

1.Маргааныг дараахь үндэслэлээр хуралдаанд бэлтгэх шатнаас эхлэн дахин хянан шийдвэрлэнэ:

1/Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй;

2/урьд шийдвэрлэсэн маргааныг дахин хянан шийдвэрлэх талаар Цэцийн гишүүдийн олонхи санал гаргасан;

3/шинэ нөхцөл байдал илэрсэн.

2.Цэцийн дарга маргааныг дахин хянан шийдвэрлэх тухай тогтоол гаргана.

3.Маргааныг дахин хянан шийдвэрлэхэд энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд харин уг маргааныг урьд нь шалгасан Цэцийн гишүүн дахин шалгаж болохгүй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Цэцийн шийдвэр

**31 дүгээр зүйл.Цэцийн шийдвэрийн хэлбэр**

1.Цэцийн шийдвэр нь дүгнэлт, тогтоол, магадлал гэсэн хэлбэртэй байна.

2.Цэц энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан маргааныг хянан шийдвэрлэж дүгнэлт; мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан маргааныг дахин хянан шийдвэрлэж тогтоол; энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан маргаан болон дунд, их суудлын бүрэлдэхүүнтэй хуралдааны явцад шийдвэрлэсэн асуудлаар магадлал гаргана.

**32 дугаар зүйл.Цэц шийдвэр гаргах**

1.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтэд тавьсан шаардлагыг бүрэн хангах буюу хэрэгсэхгүй болгох, эсхүл зарим хэсгийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гаргана. Ийнхүү шийдвэрлэхдээ гагцхүү хуралдааны явцад батлагдсан баримт нотолгоог үндэслэнэ.

2.Хуралдаанаас гаргах дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар; маргааныг эцэслэн шийдвэрлэхээр дахин хянаж байгаа хуралдаанаас гаргах тогтоолыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар гаргана.

3.Цэцийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг нэн таруй уншин сонсоно.

**33 дугаар зүйл.Цэцийн шийдвэрийн агуулга**

Цэцийн шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

1/шийдвэрийн нэр, гаргасан он, сар, өдөр, цаг, газар, байр;

2/Цэцийн хуралдааныг даргалагч, оролцсон гишүүд, гарийн бичгийн даргын нэр;

3/маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгч, орчуулагч, гэрч, шинжээчийн нэр;

4/өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргагчийн нэр, тэдгээрийн тавьсан шаардлага;

5/тухайн маргааныг Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай болон энэ хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг баримтлан хэлэлцсэн;

6/үйл ажиллагаа бууу шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн гэж маргаж байгаа албан тушаалтны нэр, хаяг, эрхэлсэн ажил;

7/Цэцийн хуралдаанаар хянан хэлэлцээд тогтоосон нөхцөл, байдал;

8/Цэцийн шийдвэрийн үндэслэл болон нотлох баримт, материалын тухай дүгнэлт;

9/Цэцээс шийдвэр гаргахдаа удирдлага болгосон хуулийн зүйл, хэсэг, заалт;

10/Цэцээс маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай.

**34 дүгээр зүйл. Цэцийн шийдвэрийг мэдээлэх**

1.Цэцийн шийдвэрийн товч агуулгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нэн даруй мэдээлнэ. Цэцийн хаалттай хуралдааны шийдвэрээс шаардлагатай хэсэг, заалтын агуулгыг нийтэд мэдээлнэ.

2.Цэцийн нээлттэй хуралдааны шийдвэрийг бүрэн эхээр нь "Төрийн мэдээлэл" сэтгүүлд нийтэлнэ.

**35 дугаар зүйл. Цэцийн хуралдааны тэмдэглэл**

1.Цэцийн хуралдааны явцыг тасралтгүй, үгчлэн тэмдэглэнэ.

2.Цэцийн хуралдааны тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

1/хуралдаан болсон он, сар, өдөр, газар, байр, хуралдаан эхэлсэн, дууссан цаг, минут;

2/хуралдаан даргалагч, оролцсон гишүүд, нарийн бичгийн даргын нэр;

3/маргагч талууд болон бусад оролцогчдын нэр, эрхэлсэн ажил;

4/хянан шийдвэрлэсэн маргааны утга;

5/хуралдааны бүрэн явц;

6/маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, гэрч, шинжээчээс гаргасан мэдүүлэг, тайлбар, дүгнэлт, хүсэлт, асуулт, хариулт;

7/хуралдааны явцад гарсан зарим асуудлыг шийдвэрлэсэн ам магадлал;

8/бусад.

3. Зөвлөлдөөний тэмдэглэлийг хуралдааны нарийн бичгийн дарга тусгайд нь хөтөлнө. Уг тэмдэглэлийг Зайгууллагын нууцын зэрэгт хамааруулан хадгална.

4. Хуралдааны тэмдэглэлийг аль болох бүрэн гүйцэд сөтлөхийн тулд техник хэрэгсэл ашиглах бөгөөд гүүнийг 7 хоногоос хэтрэхгүй хугацаанд бэлэн болгож гаргаан хянан шийдвэрлэсэн материалд хавсаргана.

5. Тэмдэглэлд хуралдаан даргалагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

### 36 дугаар зүйл. Цэцийн шийдвэрийг биелүүлэх

1. Цэцийн шийдвэрийг Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хууль зүйн яам, маргагч талууд болон "Төрийн мэдээлэл" сэтгүүлд тус тус түргүүлнэ.

2. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор; хэрэв Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт гаргасан бөгөөд тэр нь онц болон, дайны байдал зарласнаас бусад асуудлаар гарсан бол Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

3. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг эцэ бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг хнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг үлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.

4. Цэцийн эцсийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон хууль Цэцийн тогтоол гармагц хүчингүй болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 1-ний өдөр

Улаанбаатар  
хот

**АУДИТЫН ТУХАЙ**  
**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь аудитын үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, мэргэшсэн нягтлан бодогч, аудитын байгууллагад аудитын үйл ажиллагаа явуулах эрх олгох, хяналт тавих, тэдний бүрэн эрхийг зөвшөөрөх, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Аудитын тухай хууль тогтоомж**

1. Аудитын тухай хууль тогтоомж нь Нягтлан бодох бүртгэлийн хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд аудитын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо**

Энэ хуульд заасан дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1/ "Аудитын үйл ажиллагаа" гэж аудитор, аудитын байгууллагаас хууль, гэрээний дагуу хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхэлж байгаа иргэнийг санхүүгийн баримтыг шалгах, магадлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах, санхүүгийн асуудлыг судалж төлөвлөх талаар үйлчлүүлэгчид зөвлөх, туслэх хараат бус үйл ажиллагааг;

2/ "Мэргэшсэн нягтлан бодогч" гэж Нягтлан бодох бүртгэлийн хууль болон энэ хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас олгосон эрхийн дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн нягтлан бодогчийг;

3/ "Аудитор" гэж энэ хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас аудитын үйл ажиллагаа явуулах лицензи авсан мэргэшсэн нягтлан бодогчийг;

4/ "Аудитын байгууллага" гэж энэ хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас аудитын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгжийг;

5/"Санхүүгийн тайлан" гэж үлдэгдэл баланс, орлого, үр дүнгийн тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тэдгээрт хавсаргасан тайлбар, тодруулга, хавсралт тооцоог;

6/"Санхүүгийн тайланг баталгаажуулах" гэж аудитын үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг батлагдсан стандартын дагуу шалгаж, үнэн зөв болохыг нотолсон дүгнэлт гаргахыг;

7/"Санхүүгийн баримт" гэж хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн асуудалтай холбоо бүхий нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодотгол, өмч, хөрөнгө, авлага, зээл, өр төлбөр, албан татвар, хураамж, шимтгэл зэрэг баримтыг;

8/"Захиалагч" гэж аж ахуйн нэгж, байгууллагад аудит хийлгэх тухай шийдвэр гаргах эрх бүхий төрийн захиргааны болон хууль, хяналт, санхүү, татвар, банк, гаалийн байгууллагыг;

9/"Үйлчлүүлэгч" гэж гэрээний үндсэн дээр аудит хийлгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг хэлнэ.

#### **4 дүгээр зүйл.Аудитын үйл ажиллагаа**

Аудитын үйл ажиллагаанд:

1/хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгч иргэний санхүүгийн баримтыг захиалагч, үйлчлүүлэгчийн хүсэлтээр шалгаж баталгаажуулах;

2/санхүүгийн баримтын шалгалт хийж дүгнэлт гаргах;

3/албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцоог хянах, дүгнэлт гаргах, татварын мэдүүлгийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх;

4/санхүүгийн байдлыг судалж төлөвлөх, хөрөнгө оруулалт, зээл, тооцооны төрөл бүрийн төсөл, төлөвлөгөө, хөрөнгийн ба бизнесийн үнэлгээ боловсруулахад нь тусалж үйлчлэх;

5/нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, нөхөн хөтлөх, тайлан гаргах, өртгийн болон удирдлагын бүртгэлийг зохион байгуулахад нь туслах, зөвлөгөө өгөх;

6/аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг зохион байгуулахад нь туслах;

7/аж ахуйн нэгж, байгууллагад менежментийн асуудлаар зөвлөгөө өгөх;

8/үнэт цаас гаргахтай холбогдсон эдийн засгийн тооцоо, судалгааны үндэслэлийг хянаж дүгнэлт гаргах;

9/аудитын үйл ажиллагааны хүрээнд хамруулахаар хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагаа хамаарна.

#### **5 дугаар зүйл.Аудитын үйл ажиллагааны зарчим**

Аудитын үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

1/аудитын үйл ажиллагаанд хуулийг чандлан сахиж, олон улсын аудитын стандартад заасан арга, хэлбэрээр аудитын үйл ажиллагааг явуулна;

2/аудитын үйл ажиллагаа хараат бус байна. Мэргэшсэн нягтлан бодогчийн үйл ажиллагаа бодитой, бие даасан байхаас гадна, бие даасан байдлыг нь алдагдуулахад нөлөө үзүүлж болох аливаа шахалт, эрхшээлд орох нөхцөл бүрэлдэхээс урьдчилан харж зайлсхийнэ. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан аудиторын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, шахалт үзүүлэхийг хориглоно;

3/мэргэшсэн нягтлан бодогч аудитын үйлчилгээг чанартай гүйцэтгэх мэргэшлийн шаардлага хангасан байна;

4/захиалагч, үйлчлүүлэгч шалгалт, магадлан шинжилгээ хийлгэх, мэргэжлийн туслалцаа авах аудиторыг чөлөөтэй сонгох, хуулийн дагуу заавал магадлан шинжилгээ хийх тохиолдолд томилогдсон аудиторыг энэ хуульд заасан үндэслэл байвал татгалзах эрхтэй;

5/аудитын үйл ажиллагаа гүйцэтгэсэн этгээд шалгалт, магадлан шинжилгээ, баталгаажуулалтыг буруу хийснээс холбогдогч талд хохирол учруулбал өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө;

6/аудитын үйл ажиллагаанд мэдээллийн нууцыг хадгална. Аудитор нь үйл ажиллагааны явцад олж авсан үйлчлүүлэгчийн мэдээллийг хуульд тусгайлан заагаагүй бол бусдад мэдээлэхгүй байхын зэрэгцээ уул мэдээллийг хувийн эсвэл гуравдагч талын ашиг сонирхлын тулд ашиглаж үл болно;

7/аудитын үйл ажиллагаанд шударга бус өрсөлдөөнийг хориглоно. Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, аудитын байгууллагын зар сурталчилгаа нь бодитой бөгөөд бусдыг төөрөгдөлд оруулахааргүй, мөн бусад аудитор болон аудитын байгууллагатай харьцуулсан буюу тэдний нэр төрд харшлагааргүй байвал зохино.

#### **6 дугаар зүйл. Аудитын үйл ажиллагаа явуулах**

##### **үндэслэл**

1. Аудитын байгууллага дараахь тохиолдолд аудитын үйл ажиллагаа явуулна:

1/хуульд санхүүгийн тайлангаа заавал баталгаажуулахаар заасан;

2/аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, удирдах ажилтан аудит хийлгэх тухай хүсэлт гаргаж гэрээ байгуулсан;

3/захиалагчийн аудит хийлгэх тухай шийдвэрийг үйлчлүүлэгч хүлээн авч аудитын байгууллага сонгон гэрээ байгуулсан.

2. Үйлчлүүлэгч аудит хийлгэсэн үйлчилгээний хөлсийг гэрээний үндсэн дээр төлнө.

#### **7 дугаар зүйл. Санхүүгийн тайлангаа баталгаажуулах**

##### **байгууллага**

1. Дараахь аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар заавал баталгаажуулна:

1/хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх төрлийн хувьцаат компани;  
 2/хөрөнгийн биржид бүртгүүлэх зөвшөөрөл хүсч буй компани;  
 3/30 сая, түүнээс дээш төгрөгийн дүрмийн сан бүхий аж ахуйн  
 нэгж;

4/бүх хөрөнгөө дуудлагын худалдаанд гаргах гэж буй аж ахуйн  
 нэгж;

5/хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй  
 юл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага;

6/төрийн өмчийн болон төрийн өмч оролцсон аж ахуйн нэгж;

7/банк, санхүү, даатгалын байгууллага;

8/брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг үнэт цаасны  
 компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа  
 явуулдаг компани;

9/үйлдвэрчний эвлэлийн байгууллага.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж,  
 байгууллага өөрийн санаачилгаар аудитын байгууллагаар санхүүгийн  
 айлангаа баталгаажуулж болно.

#### **8 дугаар зүйл.Аудитын стандарт**

Аудитын үйл ажиллагаа явуулах, санхүүгийн тайлан баталгаа-  
 куулах, дүгнэлт, магадлагаа гаргах стандартыг Сангийн сайд батлах  
 явцад энэ нь олон улсын аудитын стандартын зарчимд нийцсэн  
 байна.

#### **9 дүгээр зүйл.Санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулах**

1.Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, баримтыг  
 аудитын байгууллага баталгаажуулна.

2.Аудитор шалгасан буюу судалсан тайлан, санхүүгийн баримтад  
 увийн тэмдэг дарах бөгөөд түүний гаргасан дүгнэлтэд аудитын  
 айгууллагын дарга /захирал/ гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг  
 арж баталгаажуулна.

#### **10 дугаар зүйл.Гэрээ, удирдамж**

1.Аудит хийх талаар үйлчлүүлэгч болон аудитын байгууллага  
 ичгээр гэрээ байгуулна. Гэрээ нь үйлчлүүлэгч ба аудитын  
 айгууллагын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг  
 арсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

2.Гэрээнд аудитын үйл ажиллагаатай холбогдуулж харилцан  
 үлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр  
 үнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмын тухай заасан  
 байна.

3.Үйлчлүүлэгч болон аудитын байгууллагын хооронд байгуулсан  
 үчин төгөлдөр, урт хугацааны гэрээний хүрээнд аудитын үйл  
 жиллагааны аль нэгэн төрлийг гүйцэтгэх аудитор нь аудитын

байгууллагын эрх баригчаас баталсан удирдамжтай байна. Энэхүү удирдамж нь гэрээний агуулгатай бүрэн нийцсэн байвал зохино.

### 11 дүгээр зүйл. Үйлчлүүлэгч байгууллагын эрх,

#### үүрэг

1. Үйлчлүүлэгч байгууллага дараахь эрх эдэлнэ:

1/аудитын байгууллагыг сонгох;

2/аудитын дүгнэлтийн талаар тайлбар өгөхийг шаардах;

3/аудитын дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол энэ талаар шүүхэд гомдол гаргах.

2. Үйлчлүүлэгч байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1/аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;

2/шалгалтад шаардлагатай баримт, мэдээллийг гаргаж өгөх;

3/байгууллагын аж ахуй, санхүүгийн бүх үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусгасан, мөн эдгээртэй холбогдох баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулах бөгөөд энэ талаар үүсч болох хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг аудиторт гаргаж өгөх;

4/шалгалтын явцад илэрсэн бүртгэл хөтлөлтийн болон санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчлийг шуурхай залруулах;

5/шалгуулж буй байгууллагын удирдлагын зүгээс шалгалтад саад учруулахгүй байх.

3. Санхүүгийн тайланг баталгаажуулахтай холбогдсон хариуцлагыг аудитын байгууллага хүлээнэ.

4. Аудиторг гаргаж танилцуулсан санхүүгийн баримтын үнэн зөв, бодитой байх хариуцлагыг үйлчлүүлэгч байгууллагын удирдах ажилтан хүлээнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор

#### 12 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх

##### олгох шалгалтад орох нөхцөл

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орох хүн дараахь нөхцөлийг хангасан байна:

1/их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогчийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй буюу эсвэл түүнтэй адилтгах зэрэглэлийн сургалтаар төгссөн байх;

2/мэргэжлээрээ 2-оос доошгүй жил аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодогчоор ажилласан, мэргэжлийн сургуульд багш, төрийн байгууллага, түүнчлэн татварын алба, аудитын байгууллагад мэргэжлээрээ ажилласан;

3/ энэ хууль гарахаас өмнө мэргэжлийн их, дээд сургууль, коллежийг нягтлан бодогч мэргэжлээр төгсөгчид санхүүгийн болон этгийн бүртгэл, бүртгэлийн мэдээллийн тогтолцоо, аудит, менежментийн зөвлөгөө өгөх үйлчилгээ зэрэг дамжаануудыг төгссөн байх.

#### 13 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн

##### эрх олгох шалгалт

1. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг Сангийн ядын дэргэдэх Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл аашид "Мэргэжлийн зөвлөл" гэх/ жилд нэгээс доошгүй удаахион байгуулна.

2. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт авах журмыг мэргэжлийн зөвлөлийн санал болгосноор Сангийн сайд батална.

#### 14 дүгээр зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн

##### гэрчилгээ, хувийн тэмдэг

1. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад тэнцээлэнгэл Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ, хувийн тэмдгийг Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн Сангийн ядын шийдвэрээр олгоно.

2. Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээнд эзэмшигчийн овог, нэр, олгосон он, сар, өдөр, гэрчилгээний дугаар байхын хамт Сангийн сайд, Мэргэжлийн зөвлөлийн дарга гарын үсэг зурсан байна.

3. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг эхний удаа 2 жилээр, шинэ шалгалт өгч тэнцсэн бол 5 жилээр, 3 дахь удаа шалгалт өгч тэнцсэн тохиолдолд бүрмөсөн олгоно.

4. Мэргэшсэн нягтлан бодогчийн хувийн тэмдэгт "Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч" гэсэн үг бүхий хүрээний дотор овог, нэр, гэрчилгээний дугаарыг бичсэн байна.

#### 15 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн тангараг,

##### ёс зүйн дүрэм

1. Мэргэшсэн нягтлан бодогч "Би Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйг чандлан сахихаа нэр төртэйгээр батлан гаргаж, хэмээн тангараг өргөнө.

2. Тангараг өргөх ажиллагааг Мэргэжлийн зөвлөл зохион байгуулна.

3. Тангараг өргөсөн иргэн мэргэшсэн нягтлан бодогчийн тангарагийн бүрэн бичвэр бүхий тангарагийн бичигт тангараг өргөсөн он, сар, өдөр, газар, овог, нэрээ бичиж гарын үсэг зурна.

4. Мэргэшсэн нягтлан бодогч ёс зүйн дүрэмтэй байна. Ёс зүйн тэмдгийг мэргэшсэн нягтлан бодогчийн байгууллагаас батална.

**16 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн  
эрхийг дуусгавар болгох**

Дараахь нөхцөлд мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг дуусгавар болсон гэж үзнэ:

- 1/нас барсан;
- 2/өөрөө татгалзсан;
- 3/эрхийг нь хассан.

**17 дугаар зүйл. Аудитын үйл ажиллагаа явуулах  
лицензи**

1. Мэргэшсэн нягтлан бодогч Сангийн сайдын баталсан журмын дагуу мэргэжлийн зөвлөлөөс лицензи авснаар аудитын үйл ажиллагаа явуулах эрх эдэлнэ.

2. Аудитын үйл ажиллагаа явуулах лицензийг хоёр жил тутай шинэчлэн олгож байна.

3. Гадаад улсад мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн гэрчилгээ авсан Монгол Улсын болон гадаад улсын иргэн зохих журмын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн талаар шалгалт өгч тэнцсэн тохиолдолд Мэргэжлийн зөвлөл аудитын үйл ажиллагаа явуулах лицензи олгож болно.

4. Энэхүү хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дах заалтын дагуу эрхээ хасуулсан хугацаанд, түүнчлэн шалгалт өгөөгүй буюу шалгалтад тэнцээгүй иргэнд аудитын үйл ажиллагаа явуулах лицензи олгохгүй.

**18 дугаар зүйл. Хэвлэлд мэдээлэх**

Мэргэжлийн зөвлөл бүртгэсэн болон бүртгэлээс хасса мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын тухай мэдээллийг төрийн хэвлэлд нийтлүүлнэ.

**19 дүгээр зүйл. Аудиторын үүрэг**

Аудитор дараахь үүрэг хүлээнэ:

1/аудитын үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд, хууль тогтоомж, батлагдсан стандартын дагуу явуулах;

2/аудит хийж болохгүй нөхцөл байдал байгаа бол уг үйл ажиллагааг явуулахаас татгалзах эсхүл бусад аудитор, мэргэжилтэй нэмж оруулах шаардлагатай байвал үйлчлүүлэгч буюу холбогдот аудитын байгууллагад нэн даруй мэдэгдэх;

3/бусад мэргэшсэн нягтлан бодогчийн нэр хүндийг гутаах үйлдэл хийхгүй байх;

4/аудит хийх явцад олж авсан аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хуулинд зааснаас өөр тохиолдолд бусад мэдээлэхээс татгалзах. Энэ нь аудиторын үүрэг гүйцэтгэхинд больсноос хойш нэгэн адил хүчинтэй байна;

5/үйлчлүүлэгч хүсвэл шалгалтын дүн, санхүүгийн тайлан баталгаажуулсан дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг тайлбарлаж өгөх;

6/Сангийн сайдын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Мэргэжлийн зөвлөлөөс зохион байгуулах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах.

## **20 дугаар зүйл.Аудиторын эрх**

Аудитор дараахь эрх эдэлнэ:

1/үйлчлүүлэгчдээс гэрээнд заасан ажлын хүрээнд холбогдолтой санхүүгийн баримт, эрхийн актыг шаардаж авах, мөнгө, үнэт цаас, биет болон биет бус хөрөнгийг тоолох, шалгалтын явцад гарсан аливаа асуудлаар тайлбар гаргуулах;

2/аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай шууд холбоотой бичиг баримтыг холбогдох ирилжааны банк, бусад санхүүгийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас шаардан авч танилцах;

3/үйлчлүүлэгч нь шалгалтад шаардлагатай баримт, тайлбарыг бүрэн хэмжээгээр гаргаж өгөөгүй нөхцөлд аудит хийхээс татгалзах;

4/аудитор туслагчтай байж болно. Туслагч санхүүгийн баримт баталгаажуулахгүй. Аудитор болон туслагчийн харилцааг хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.

## **21 дүгээр зүйл.Аудиторын эрхийн хязгаар**

1.Аудитор дараахь аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахаас татгалзана:

1/өөрийн ажилладаг болон сүүлийн 2 жилийн дотор ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага;

2/сүүлийн нэг жилийн дотор өөрөө эд хөрөнгийн талаар компанийн нийт гаргасан хувьцаа, ногдол хувийн 5-аас дээш хувийг эзэмшдэг, эсхүл эзэл, төлбөр болон хөрөнгө оруулалтын алаар харилцаатай/ холбоотой байсан буюу одоо мөн тийм холбоотой аж ахуйн нэгж, байгууллага;

3/өөрийн ойрын садан төрлийн хүн /эцэг, эх, нөхөр, эхнэр, үүхэд, төрсөн ах, эгч, дүү нар/ удирдах албан тушаал /эзэн, дарга, ахирал, түүний орлогчид, ерөнхий нягтлан бодогч ба түүнтэй дилтгах албан тушаал/-д ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага.

## **2.Аудитор дараахь зүйлийг хориглоно:**

1/аудитын нэг байгууллагад үндсэн орон тоонд ажилладаг аудитор өөр байгууллагад давхар ажил эрхлэх болон бусад аудитын байгууллагад гэрээгээр ажиллах;

2/аудитын нэг байгууллагад гэрээгээр ажилладаг аудитор өөр аудитын байгууллагад гэрээгээр ажиллах;

3/аудитын нэг байгууллагад ажиллаж байгаа аудитор үйлчлүүлэгчдийг татах зорилгоор хоорондоо өрсөлдөх аливаа үйлдэл ийх.

## **22 дугаар зүйл.Сахиугын шийтгэл**

1.Хууль тогтоомж, ёс зүйн дүрэм зөрчсөн мэргэшсэн нягтлан бодогч, аудиторт сахилгын дараахь шийтгэл ногдуулна:

1/сануулах;

2/аудитын үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

3/мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хасах.

2.Эрх нь хасагдсан мэргэшсэн нягтлан бодогч буюу аудитор 3 жилийн дараа зохих журмын дагуу шинээр эрх авах тухай хүсэлт гаргаж болно.

3.Мэргэшсэн нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах журмыг Мэргэжлийн зөвлөлийн саналыг үндэслэн Сангийн сайд батална.

4.Энэ зүйлийн нэг дэх хэсгийн 2, 3-т заасан шийтгэл ногдуулсан тохиолдолд энэ тухай нийтэд мэдээнэ.

5.Мэргэшсэн нягтлан бодогч сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

6.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

7.Сахилгын шийтгэл хүлээлгэсэн өдрөөс хойш нэг жилийн дотор дахин сахилгын шийтгэл хүлээлгээгүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Аудитын байгууллага

#### 23 дугаар зүйл.Аудитын байгууллага

Аудитын байгууллага нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа явуулах хувьцаат компани, хоршооноос бусад хэлбэрээр зохион байгуулагдсан аж ахуйн нэгж байна.

#### 24 дүгээр зүйл.Аудитын байгууллагын нэр

Аудитын байгууллагын оноосон нэрийн ард "Аудит" гэсэн үгийг бичсэн байна.

#### 25 дугаар зүйл.Аудитын байгууллагад тавих шаардлага

Аудитын байгууллага дараахь шаардлагыг хангасан байна:

1/аудитын үйл ажиллагаа эрхлэгчид нь зөвхөн аудитор байх;

2/байгууллагын удирдлага /дэргэ, захирал/ болон мэргэжлийн шийдвэр гаргах эрхтэй албан тушаалтан нь аудитор байх;

3/үндсэн орон тооны 2-оос доошгүй аудитортай байх;

4/үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгслээг хангагдсан байх;

5/энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас бусад болон бусдад хараат олж болох үйл ажиллагаа эрхлэхгүй байх.

**26 дугаар зүйл. Аудитын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл**

1. Аудитын байгууллага байгуулах болон аудитын үйл ажиллагаа вуулах хүсэлтэй аж ахуйн нэгж дараахь бичиг баримтыг бүрдүүлж Лэргэжлийн зөвлөлд ирүүлнэ:

- 1/тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;
- 2/мэргэшсэн нягтлан бодогчдын товч бүртгэл;
- 3/аудитын байгууллага үүсгэн байгуулах гэрээ;
- 4/нөхөрлөл, компанийн дүрэм.

2. Аудитын байгууллага байгуулах тухай хүсэлтийг Мэргэжлийн өвлөл хянаж, шаардлага хангасан гэж үзвэл түүний мэдүүдснээр угсай зөвшөөрлийг Сангийн сайд олгоно.

**27 дугаар зүйл. Аудитын байгууллагыг бүртгэх**

Аудитын байгууллага энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан тусгай эвшөөрлийг авсны дараа Нөхөрлөл, компанийн тухай хуулийн агуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

**28 дугаар зүйл. Дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх**

Аудитын байгууллага дүрэмдээ оруулсан өөрчлөлтийг тухай бүр лэргэжлийн зөвлөлөөр хянуулж улсын бүртгэлд бүртгүүлнэ.

**29 дүгээр зүйл. Аудитын байгууллагын үйл ажиллагааг хязгаарлах**

Аудитын байгууллага дараахь аж ахуйн нэгж, байгууллагын инхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахыг хориглоно:

- 1/аудитын байгууллага өөрөө хөрөнгө оруулсан;
- 2/өөртэй нь эд хөрөнгийн талаар холбоотой;

3/нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулах, бүртгэлийн итолцоог өөрчлөх, санхүүгийн тайлан гаргахад нь мэргэжлийн /слалцаа үзүүлсэн.

**30 дугаар зүйл. Аудитын байгууллагын эрхийг хасах**

1. Аудитын байгууллага нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн иргасан хууль тогтоомж, эрх зүйн актын заалтыг зөрчсөн ххиолдолд түүний аудитын үйл ажиллагаа явуулах эрхийг Сангийн ийдын тушаалаар хасна.

2. Эрхийг нь хассан аудитын байгууллагын тухай түүнийг /ртгэсэн улсын бүртгэлийн байгууллагад Мэргэжлийн зөвлөл эдээлж байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл

#### 31 дүгээр зүйл. Мэргэжлийн зөвлөл, түүнийг байгуулах

1. Монгол Улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор Мэргэжлийн зөвлөл Сангийн сайдын дэргэд ажиллана. Мэргэжлийн зөвлөлийн дүрмийг Сангийн сайд батална.

2. Мэргэжлийн зөвлөлийг төрийн ба төрийн бус байгууллагын төлөөдөлтэйгээр дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Сангийн сайдын тушаалаар байгуулна.

3. Мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүдийг 5 хүртэл жилийн хугацаагаар томилно.

4. Мэргэжлийн зөвлөлийн дарга орон тооны байх бөгөөд зарим гишүүн нь бүрэн бус ажлын цагаар ажиллаж болно.

#### 32 дугаар зүйл. Мэргэжлийн зөвлөлийн бүрэн эрх

Мэргэжлийн зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/санхүүгийн бүртгэл, аудитын үйл ажиллагааны стандартыг боловсруулах, боловсронгуй болгох талаар санал гаргах, тэдгээрийг мөрдүүлэх талаар хяналт тавих;

2/нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хянан үзэх;

3/мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, тэнцсэн хүмүүст мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох асуудлыг Сангийн сайдад тавьж шийдвэрлүүлэх;

4/мэргэшсэн нягтлан бодогчид эрхийн гэрчилгээ олгож, бүртгэл хөтлөх;

5/дотоод, гадаадын мэргэшсэн нягтлан бодогчид аудитын үйл ажиллагаа явуулах лицензийг хууль тогтоомжийн дагуу олгох;

6/аудитын байгууллага байгуулах, аудитын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлтийг хянан үзэж тусгай зөвшөөрөл олгох асуудлыг Сангийн сайдад тавьж шийдвэрлүүлэх;

7/аудитын байгууллагын оноосон нэр, хариуцлагын хэлбэр удирдлага, гишүүдийн овог, нэр, ажиллагсдын тоо, харилцах хаяг болон бусад үзүүлэлтийг тусгасан бүртгэл хөтлөх;

8/мэргэшсэн нягтлан бодогч, аудитын байгууллагад энэ хууль болон бусад хууль тогтоомж, мэргэшсэн нягтлан бодогчдын байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйг чанд сахин мөрдөж явдлыг хангуулах;

9/энэ зүйлийн 8 дахь хэсгийн заалттай холбогдуулан өөрийн санаачилгаар болон захиалагч, үйлчилгээгчийн санал, гомдлын дагуу аудитор болон аудитын байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, холбогдох дүгнэлт, саналаа Сангийн сайдад тавьж шийдвэрлүүлэх;

10/нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалт батлагдсан хөтөлбөрийн шаардлагыг хангахгүй байгаа бол сургалтын зөвшөөрлийг хүчингүй болгох тухай саналыг Зөвлөсрөлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавих;

11/бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай санхүүжилтийг төрийн төлбөрт үйлчилгээ, захиалгын журмаар авч болох бөгөөд мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт зохион байгуулах, аудитын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагаатай холбогдуулан үйлчилгээний хөлс авах. Үйлчилгээний хөлсний гэмжээ нь зардлаа бүрэн нөхөх боломжтой байна.

### 33 дугаар зүйл. Дарга, гишүүнд тавих шаардлага

Мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүн дараахь шаардлагыг хангасан байна:

1/Монгол Улсын иргэн байх;

2/зохих журмын дагуу бүртгүүлсэн мэргэшсэн нягтлан бодогч байх;

3/мэргэшсэн нягтлан бодогчоор бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил төрийн захиргааны мэргэжлийн болон аудитын байгууллагад ажилласан буюу их, дээд сургууль, коллежид ажилласан байх;

4/хуулийн өмнө хариуцлага хүлээх чадвартай байх;

5/мэргэжлийн ёс зүйн шаардлагыг хангасан байх.

### 34 дүгээр зүйл. Дарга, гишүүнийг чөлөөлөх

1. Дарга, гишүүнийг дараахь үндэслэлээр чөлөөлнө:

1/эрүүл мэндийн хувьд энэ үүргийг гүйцэтгэж чадахгүй болсон;

2/өөрөө хүсэлт гаргасан;

3/хууль тогтоомж, мэргэжлийн ёс зүйг зөрчсөн нь нотлогдсон;

4/эрүүгийн гэмт хэрэгт шийтгүүлж шүүхийн таслан шийдвэрлэх огтоол хүчин төгөлдөр болсон.

2. Мэргэжлийн зөвлөлийн дарга, гишүүний үйл ажиллагааг Сангийн сайдын томилсон шалгагч шалгах тохиолдолд уг этгээд өөрөө шалгалтад оролцох буюу нөлөөлж болохгүй.

### 35 дугаар зүйл. Мэргэжлийн зөвлөлийн санхүүжилт

1. Мэргэжлийн зөвлөл үйл ажиллагаагаа үйлчилгээний хөлс олон бусад эх үүсвэрээс санхүүжүүлж явуулна.

2. Мэргэжлийн зөвлөл санхүүгийн эх үүсвэрийг зөвхөн үндсэн үрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор зарцуулна.

3. Мэргэжлийн зөвлөлийн санхүүгийн тайланг Сангийн яам хянана.

### 36 дугаар зүйл. Нэр ашиглахыг хязгаарлах

1. Мэргэшсэн нягтлан бодогчоос өөр иргэн мэргэшсэн нягтлан бодогч болон түүнтэй эндүүрч болох өөр цол хэргэм, зэрэг дэв ашиглахыг хориглоно.

2. Аудитын байгууллагаас өөр этгээд "Аудит" гэсэн үг буюу түүнтэй эндүүрч болох бусад үгийг байгууллагын нэрэнд хэрэглэхийг хориглоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Аудитын тухай хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

#### 37 дугаар зүйл. Аудитор, аудитын байгууллагад хүлээлгэх хариуцлага

1. Аудитын тухай хууль тогтоомж зөрчсөн аудитор, аудитын байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/энэ хуулийн 21, 30 дугаар зүйлийг зөрчсөн бол аудиторыг 30000-40000 төгрөгөөр, аудитын байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгох;

2/санхүүгийн тайланг буруу баталгаажуулсан зэрэг аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчиж хангалтгүй үйлчилгээ үзүүлсний улмаас захиалагч, үйлчлүүлэгч ба бусад этгээдэд эд хөрөнгийн хохирол учруулсан бол уг хохирлыг аудитын байгууллагаар нөхөн төлүүлж, аудиторыг 40000-50000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн бол энэ үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, иргэнийг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-150000 төгрөгөөр тус тус торгоно.

2. Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### 38 дугаар зүйл. Захиалагч, үйлчлүүлэгчид хүлээлгэх хариуцлага

1. Энэ хууль бусад хууль тогтоомж зөрчсөн захиалагч, үйлчлүүлэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинж байдлыг харгалзан гэм буруутай этгээдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

1/энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тайлангаа баталгаажуулахаас зайлсхийсэн бол албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;

2/санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахад санаатайгаар саад учруулсан бол албан тушаалтныг 30000-40000 төгрөгөөр, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

2.Энэ зүйлийн 1, 2-т заасан үйлдэл нь аудитын байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан бол уг хохирлыг гэм буруутай албан тушаалтан буюу байгууллагаар нөхөн төлүүлнэ.

#### **39 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигч бусад этгээдэд хүлээлгэх хариуцлага**

1.Үйлчилүүдэгчтэй ажил төрлийн холбоотой албан тушаалтан ба байгууллага нь санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахад шаардлагатай баримт, бусад материалыг танилцуулах, тайлбар гаргаж өгөхөөс татгалзаж аудитын үйл ажиллагаанд саад учруулсан бол шүүх албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгоно.

2.Аудитын үйл ажиллагаа явуулах эрхгүй этгээд энэ төрлийн үйл ажиллагаа явуулсан бол шүүх олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 40000-50000, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгоно.

3.Аудитын үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөлгүйгээр энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчлийг давтан үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгах асуудлыг шүүх хобогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.Шүүх энэ хуулийн 36 дугаар зүйлийг зөрчсөн гэм буруутай иргэнийг 25000-50000 төгрөгөөр, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгоно.

#### **40 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 1997 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ

#### Нэгдүгээр бүлэг

#### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь нотариатын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, нотариатчийн эрх зүйн байдлыг тодорхойлж, нотариатаас хэлцэл, өмчлөх эрх, хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичгийг гэрчлэх зэрэг нотариатын үйлдэл хийх замаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Нотариатын тухай хууль тогтоомж

1. Нотариатын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль, бусад хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрднө.

#### 3 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагааны зарчим

Нотариатын үйл ажиллагаанд дараахь зарчим баримтална:

1/хууль дээдлэх;

2/үйл ажиллагаагаа явуулахдаа харалт бус байх;

3/өөрийн буруутай үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг бүрэн хариуцах.

#### 4 дүгээр зүйл. Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч

1. Нотариатын үйл ажиллагааг нотариатч болон нотариатчийн үүрэг гүйцэтгэгч эрхлэн явуулна.

2. Нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн гүйцэтгэж, нотариатын үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллаж байгаа иргэнийг нотариатч гэнэ.

3. Нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хавсран эрхэлж байгаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан болон нотариатын үйл ажиллагаа эрхэлж байгаа хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг нотариатчийн үүрэг гүйцэтгэгч гэнэ.

4. Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд нотариатч нь багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж болохгүй.

**5 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамж,  
үйлчилгээний хөлс, зардал**

1. Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлсэн бол үйлчлүүлэгч нь Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд заасан журам, хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлнө.

2. Нотариатч үйлчилгээ үзүүлсэн бол үйлчлүүлэгчээс үйлчилгээний хөлс, нотариатчийн ажлын байрнаас өөр газар үйлчлүүлэгчийн хүсэлтээр очиж үйлчилсэн бол тээврийн хөлс, зөвлөгөө, мэдээлэл, тавламж өгөх, бичиг баримт боловсруулах техник үйлчилгээ үзүүлсний зардлыг авна.

3. Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас, нотариатч энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас өөр сураамж, хөлс, зардал, шагнал урамшил авахыг хориглоно.

4. Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд зааснаар зохицуулах ба үйлчлүүлэгч нь үйлчилгээний хөлс, зардал төлөх чадваргүй бол тэдгээрээс илөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, төлөх хутацааг хойшлуулах асуудлыг Нотариатчдын танхим шийдвэрлэнэ.

5. Үйлчилгээний хөлс, зардлын жишгийг Нотариатчдын танхимын анализыг үндэслэн Хууль зүйн сайд тогтооно.

**6 дугаар зүйл. Нотариатын байгууллага**

1. Нотариатчид улсын хэмжээнд үйл ажиллагаагаа уялдуулан охицуулах зорилгоор нэгдэн Нотариатчдын танхим байгуулна.

2. Нотариатчдын танхимын салбар аймаг, нийслэлд ажиллана.

3. Нэг тойрогт үйл ажиллагаа явуулах нотариатчид нэгдэн Нотариатчдын товчоо байгуулж болно.

4. Нотариатын байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээд өгөөд зохион байгуулалт, үйл ажиллагааг нь дүрмээр зохицуулна.

5. Нотариатын байгууллагыг Хууль зүйн яаманд бүртгүүлнэ.

**7 дугаар зүйл. Нотариатчдын танхимын бүрэн эрх**

1. Нотариатчдын танхим нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/нотариатчийг сонгон шалгаруулах ажил зохион байгуулах;

2/нотариатчийг бэлтгэх, сургах, давтан сургах ажил зохион айгуулах;

3/нотариатчийн үйл ажиллагаанд баримтлах аргачилсан заавар, өвлөмж боловсруулан холбогдох байгууллагаар батлуулах;

4/нотариатын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

5/нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ тогтоож, түүний биелэлтэд яналт тавих;

6/нотариатчдын үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийх;

7/нотариатчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

8/нотариатчийн хариуцлагын даатгалыг зохион байгуулах.

2.Нотариатчдын танхимын дэргэд нотариатчийг сонгон шалгаруулах мэргэжлийн, орон тооны бус комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайд батална.

3.Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан нотариатч Нотариатчдын танхимд бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулна.

**8 дугаар зүйл.Нотариатын үйл ажиллагаа явуулах хэл**

1.Нотариатын үйл ажиллагаа явуулах, бичиг баримт, нотариатын үйлдлийн тэмдэглэл үйлдэх албан ёсны хэл нь монгол хэл байна.

2.Хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн болон консулын газар нь нотариатын бичиг баримтыг монгол хэлээр хөтөлнө. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр бичиг баримтыг орчуулан өгч болно.

**9 дүгээр зүйл.Нотариатчийн тамга, тэмдэг**

1.Нотариатч нь тогтоосон загварын дагуу үйлдсэн тамга, баталгааны тусгай тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.Нотариатч өөр тойрогт шилжин ажиллах бол тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг хэвээр хэрэглэж болно.

3.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан нотариатын үйл ажиллагаа хавсран эрхлэн явуулахдаа тухайн сумын Засаг даргын, дүүргийн Засаг даргын тамгын газрын тамга, баталгааны тусгай тэмдэг хэрэглэнэ.

4.Хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн болон консулын газар нь нотариатын үйл ажиллагаа эрхлэхдээ тухайн дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тамга, баталгааны тусгай тэмдэг хэрэглэнэ.

### Хоёрдугаар бүлэг

**Нотариатчийн үйл ажиллагаа явуулах тойрог,  
нотариатчид зөвшөөрөл олгох,  
түүнийг хүчингүй болгох**

**10 дугаар зүйл.Нотариатын тойрог, нотариатчийн  
тоог тогтоох**

1.Нотариатын тойрог, түүнд ажиллах нотариатчийн тоог Хууль зүйн сайд тогтооно.

2.Аймаг, нийслэлийн Засаг дарга хүн амын байршил, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг харгалзан нотариатын тойрогт ажиллах нотариатчийн тооны талаар саналаа боловсруулж, Хууль зүйн яаманд ирүүлнэ.

### **11 дүгээр зүйл. Нотариатчийн үйл ажиллагаа явуулах харьяалал**

1. Нотариатч нь тогтоосон тойрогт үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

2. Зайлшгүй шаардлагаар өөр тойрогт нотариатын үйлдэл хийх бол Нотариатчдын танхимын салбарт мэдэгдэж зөвшөөрөл авна.

### **12 дугаар зүйл. Нотариатчийн ажлын байр**

1. Нотариатч нь үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг тойрогтоо ажлын байртай байна. Тойрог нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжээс бүрдэж байвал нэгж болгонд ажлын байртай байж болно. Нотариатын үйлдлийг ажлын байрандаа хийнэ.

2. Үйлчлүүлэгч нь эрүүл мэндийн байдлын улмаас, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар нотариатчийн ажлын байранд үйлчлүүлэх боломжгүй бол түүний хүсэлтээр байгаа газарт нь нотариатч очиж үйлчилж болно.

### **13 дугаар зүйл. Нотариатчид үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох шалгуур**

1. Нотариатчаар Нотариатчдын танхимаас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн, хууль зүйн дээд боловсролтой, 3 сараас доошгүй хугацаагаар нотариатын үйл ажиллагаа эрхэлсэн буюу нотариатын ажлын дадлага хийсэн Монгол Улсын иргэнийг ажиллуулна.

2. Өмгөөлөгч нотариатын үйл ажиллагаа хавсран эрхлэх зөвшөөрөл авахад дараахь шаардлагыг хангасан байна:

1/Хууль зүйн товчоонд харьяалагдаж, хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг байнга, тогтвортой эрхэлдэг байх;

2/Өмгөөлөгчөөр 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх;

3/Нотариатчдын танхимаас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн байх;

4/уг өмгөөлөгчийн харьяалагдах Хууль зүйн товчооны өөр өмгөөлөгч зөвшөөрөл авалгүй байх.

3. Нотариатчийг сонгон шалгаруулах журмыг Нотариатчдын танхимын саналыг үндэслэн Хууль зүйн сайд батална.

### **14 дүгээр зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл**

1. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан, энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан иргэнд нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн сайд олгох бөгөөд энэхүү зөвшөөрөл нь гэрчилгээгээр нотлогдоно.

2. Нотариатын үйл ажиллагаа хавсран эрхлэх зөвшөөрөл авсан өмгөөлөгчийн явуулах өмгөөллийн үйл ажиллагаа нь түүний нотариатчийн хувьд хийсэн үйлдэлтэй холбоогүй байна.

3. Сум, дүүрэгт нотариатч ажиллаагүй бол нотариатчийн үүргийг Хууль зүйн сайдаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр сум, дүүргийн

Засаг даргын тамгын газрын ажилтанд хавсран гүйцэтгүүлэх асуудлыг сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

**15 дугаар зүйл. Нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах**

1. Дараахь тохиолдолд иргэнийг нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзана:

1/гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлдээд ял шийтгэлгүйд тооцогдох хугацаа нь дуусаагүй бол;

2/нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөний улмаас нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь хүчингүй болгосноос хойш 3 жилийн хугацаа өнгөрөөгүй бол;

3/эрх зүйн чадамжгүй бол;

4/хууль тогтоомжид заасан бусад үндэслэл байвал.

2. Иргэн нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл, түүнийг хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

**16 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох**

Нотариатчийг эрүүгийн хариуцлагад татсан тохиолдолд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болтол нотариатын үйл ажиллагаа эрхлэхийг нь түр зогсоох шийдвэрийг Нотариатчдын танхим гаргана.

**17 дугаар зүйл. Зөвшөөрлийг хүчингүй болгох**

1. Хууль зүйн сайд дараахь тохиолдолд Нотариатчдын танхимын саналыг үндэслэн нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно:

1/нотариатч нь эрүүл мэндийн байдлын улмаас, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болбол өөрийн нь хүсэлт, эмнэлгийн магадлагаа, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн;

2/нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хуурамч бичиг баримт бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

3/нотариатч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

4/нотариатч эрх зүйн чадамжгүй болсон;

5/энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас өөр ажил, албан тушаал давхар эрхэлсэн;

6/нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн;

7/нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 2 жилийн турш, хавсран эрхэлж байгаа өмгөөлөгч 6 сарын турш нотариатын үйл ажиллагаа явуулаагүй.

2. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд нотариатч Нотариатчдын танхимын салбарт бичиг баримт, тамга, тэмдгээ хүлээлгэн өгнө.

### Гуравдугаар бүлэг

#### Нотариатчийн эрх, үүрэг, үйл ажиллагааны баталгаа

##### 18 дугаар зүйл. Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн эрх

Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нь дараахь эрх эдэлнэ:

- 1/үйлчлүүлэгчийнхээ хувийн байдлыг тогтоох;
- 2/нотариатын үйлдэл хийхэд зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг иргэн, хуулийн этгээдээс шаардан авах;
- 3/жинхэнэ эх мөн эсэх нь эргэлзээтэй байвал уг бичиг баримтыг магадлан шинжлүүлэх;
- 4/шаардлагатай гэж үзвэл холбогдох этгээдийг дуудан ирүүлэх;
- 5/хууль тогтоомжид заасан бусад эрх.

##### 19 дүгээр зүйл. Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үүрэг

Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нь дараахь үүрэг хүлээнэ:

- 1/нотариатын үйлдлийг мэргэжлийн өндөр түвшинд, бие даан, хууль тогтоомжид нийцүүлэн хийх;
- 2/нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;
- 3/иргэн, хуулийн этгээдээс эрхээ хэрэгжүүлэх, хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалахад нь үйлчлэх, тэдний эрх, үүргийг нь гайлбарлан өгч, нотариатын үйлдэл хийснээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан сануулж, зөвлөгөө өгөх;
- 4/нотариатаар гэрчлүүлэх бичиг баримтын үнэн зөв эсэхийг хянах;
- 5/нотариатын үйлдэл хийсэн бичиг баримт, мэдээллийг шүүх, прокурорын газар, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын шаардсаны дагуу өгөх.

##### 20 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагааны нууц

1. Төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах асуудлаар нотариатын үйлдэл хийж байгаа бол тэдгээрийн нууцыг холбогдох тууль заасны дагуу хамгаална.

2. Нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нь үйл ажиллагаагаа эрэгжүүлэх явцдаа олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг

задруулж болохгүй. Нотариатын үйл ажиллагаа дуусгавар болсон ч нууцыг хадгалах үүрэг хэвээр үлдэнэ.

3. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа нотариатын үйлдлийн нууцыг мэдсэн бусад хүмүүст энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт нэг адил хамаарна.

## **21 дүгээр зүйл. Нотариатын үйл ажиллагааны баталгаа**

1. Нотариатын үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, нотариатын үйлдэл хийхийг хууль бусаар шаардах, заналхийлэхийг хориглоно.

2. Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь Нотариатчдын танхим, түүний салбарыг үйл ажиллагаагаа явуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

## **22 дугаар зүйл. Нотариатчийн хариуцлагын даатгал**

1. Нотариатч нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутагдсаны улмаас нотариатын үйл ажиллагааг буруу явуулсан, үйлчлүүлэгчийн хувийн байдлыг буруу тогтоосноос түүнд хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор нотариатчийн хариуцлагын даатгалд хамрагдана.

2. Нотариатч нь нотариатчийн үйл ажиллагаанаас хохирол учирч болох тохиолдол тус бүрийг тусгасан даатгалын гэрээг Нотариатчдын танхимтай хийнэ. Нотариатчдын танхим гэрээний нөхцөл өөрчлөгдөх, хүчингүй болох, хугацаа нь дуусгавар болох тохиолдолд энэ тухай нотариатчдад нэн даруй мэдэгдэж байна.

3. Нотариатчдын танхим нь нотариатчийн хариуцлагын даатгалын сан байгуулж ажиллана. Уг сангийн ажиллах журмыг Нотариатчдын танхим тогтооно.

4. Нотариатчийн хариуцлагын даатгалын санд нотариатчийн орлогын 5 хувийг төвлөрүүлнэ.

5. Нотариатчид хариуцлагын даатгалын сангаас төлөх даатгалын төлбөрийн дээд хэмжээ нь тухайн нотариатчийн оруулсан орлогын хэмжээнээс хоёр дахин их байж болно.

6. Нотариатчийн орлогод үйлчилгээний хэлс, нотариатын үйлчилгээний талаар зөвлөгөө, мэдээлэл, лавламж өгөх, бичиг баримт боловсруулж, техник үйлчилгээ үзүүлсний орлогыг оруулан тооцно.

7. Дараахь үйлдлүүдийг хариуцлагын даатгалд хамааруулахгүй:

1/илт хайхрамжгүй буюу санаатай хууль зөрчиж хийсэн үйлдэл;

2/бусад улсын хууль тогтоомжийн талаар буруу тайлбар, зөвлөгөө өгсөн;

3/нотариатч үүргээ шударгаар биелүүлдэггүй.

## Дөрөвдүгээр бүлэг

### Нотариатын үйлдэл, түүнийг хийх журам

#### 23 дугаар зүйл. Нотариатын үйлдэл

1. Энэ бүлгийн заалт нь нотариатчийн үүрэг гүйцэтгэгчид нэг адил хамаарна.

2. Нотариатч нь дор дурдсан бичиг баримтыг гэрчлэх болон бусад үйлдэл хийнэ:

1/хэлцэл, гэрээ, итгэмжлэл;

2/хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг;

3/өв залгамжлах эрх, гэрээслэл;

4/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбогдох бичиг баримт;

5/гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх;

6/бичиг баримтын хуулбарын үнэн зөв;

7/орчуулсан бичиг баримт;

8/бичиг баримтад зурсан гарын үсгийн үнэн зөв;

9/өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох;

10/хууль тогтоомжид заасан бусад үйлдэл.

3. Нотариатын үйлдлийг эрхлэн хийх зааврыг Хууль зүйн сайд батална.

#### 24 дүгээр зүйл. Бичиг баримт гэрчлэхэд тавих шаардлага

1. Үйлчлүүлэгч, түүний эрх залгамжлагч болон итгэмжлэгдсэн иргэн, хуулийн этгээд нь уг бичиг баримтыг гэрчлүүлэх эрхтэй гэдгээ нотолно.

2. Гэрчлэгдэх бичиг баримтын эх хувь нь гаргацтай, засваргүй, утга агуулгын хувьд ойлгомжтой, тодорхой байна. Гэрээ, хэлцэл, хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг нь бичиг баримтад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байна.

3. Гэрчлэгдэх гэрээ, хэлцэл, итгэмжлэл, өв залгамжлалын гэрээслэл, хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг нь 2-оос доошгүй хувь үйлдэгдсэн байх бөгөөд түүний нэг хувийг нотариатч хадгална.

#### 25 дугаар зүйл. Бичиг баримтын хуулбарыг гэрчлэх

1. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр бичиг баримтын хуулбарыг эх хувьтай нь тулган шалгасны үндсэн дээр гэрчилнэ.

2. Хоорондоо холбоогүй хэд хэдэн асуудалд хамаарах заалт бүхий бичиг баримтын тодорхой асуудлын талаархи хэсгийг бүрэн тусгасан хэсэгчилсэн хуулбарыг гэрчилж болно.

3. Бичиг баримтын хуулбарын хуулбарыг анхны хуулбар нь урьд нотариатаар гэрчлэгдсэн буюу уг бичиг баримтыг олгосон иргэн, хуулийн этгээд үнэн зөвийг тодорхойлсон тохиолдолд гэрчилнэ.

**26 дугаар зүйл. Хуулийн этгээд үүсгэн байгуулах  
баримт бичгийг гэрчлэх**

Нотариатч хуулийн этгээд үүсгэн байгуулах гэрээ, дүрмийг хуульд заасан журмын дагуу гэрчилнэ.

**27 дугаар зүйл. Нотариатын бичиг баримт**

1. Нотариатч бичиг баримт, үйл явдлыг гэрчлэхдээ нотариатын бүртгэл хөтлөх бөгөөд шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл үйлдэнэ. Нотариатын бүртгэлд нотариатчийн хийсэн үйлдлүүдийг дэс дараагаар нь бүртгэнэ.

2. Гэрчлүүлэхээр ирүүлсэн бичиг баримтын жинхэнэ эх мөн эсэх нь эргэлзээтэй байвал нотариатч шинжилгээ хийлгэх тухай шийдвэр гаргаж болно. Шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

**28 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тогтоох**

1. Нотариатч нь нотариатын үйлдэл хийлгэхийг хүссэн үйлчлүүлэгчийн хувийн байдлыг түүний иргэний паспортыг үндэслэн тогтооно. Нотариатч нь үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээд эрх зүйн чадамжтай, итгэмжлэл, төлөөлөл нь зохих ёсоор бүрдсэн эсэхийг шалгана. Шаардлагатай бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт, эсхүл тухайн хүнийг таних хоёр гэрчээр тодорхойлуулан тогтоож болно.

2. Зайлшгүй нөхцөл байдлын улмаас нотариатын үйлдлийг яаралтай хийхэд хүрвэл үйлчлүүлэгчийн хувийн байдлыг тусгайлан тодруулахгүйгээр нотариатын үйлдэл хийж болно.

3. Үйлчлүүлэгчийн хувийн байдлыг нөхөн тодруулахад энэ хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал илрээгүй бол уг үйлдэл хүчин төгөлдөр байна.

**29 дүгээр зүйл. Үйлчлүүлэгчийн үүрэг**

1. Үйлчлүүлэгч нь дараахь үүрэг хүдээнэ:

1/нотариатын үйлдэл хийлгэх бичиг баримтыг үнэн зөв бүрдүүлж өгөх;

2/нотариатчийн шаардсан асуудлаар амаар буюу бичгээр тайлбар гаргах;

3/нотариатын үйлдэл хийх бололцоо олгох.

2. Үйлчлүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг нотариатч харнуцахгүй.

**30 дугаар зүйл. Нотариатын үйлдэл хийх хугацаа**

Нотариатын үйлдэл хийхэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж ирснээс хойш 72 цагийн дотор нотариатын үйлдэл хийх, хэрэв татгалзвал тэр тухай үндэслэлээ мэдэгдэнэ.

### **31 дүгээр зүйл. Нотариатын үйлдэл хийхийг хойшлуулах, түдгэлзүүлэх**

1. Үйлчлүүлэгч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн буюу өөрийн үйл ажиллагаанд хяналт тавих чадваргүй байгаа бол энэ нөхцөл байдлыг арилах хүртэл нотариатын үйлдэл хийхийг хойшлуулна.

2. Иргэн, хуулийн этгээдээс мэдээ, бичиг баримт нэмж гаргуулах буюу тэдгээрийг шинжлүүлэх шаардлага гарвал нотариатын үйлдэл хийхийг тодорхой хугацаагаар хойшлуулж болно.

3. Сонирхогч этгээдээс нотариатаар гэрчлүүлж байгаа бичиг баримт буюу эрхийн талаар өөр этгээд маргаж, шүүхэд нэхэмжлэл гаргасан тухай өргөдөл ирүүлбэл уг асуудлаар нотариатын үйлдэл хийхийг 14 хоног хүртэл хугацаагаар хойшлуулна. Хэрэв энэ хугацаанд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол нотариатын үйлдлийг сийнэ. Харин шүүхэд нэхэмжлэл гаргасан бол шүүхийн шийдвэр гартал нотариатын үйлдэл хийхийг түдгэлзүүлдэг.

### **32 дугаар зүйл. Нотариатын үйлдэл хийхээс татгалзах**

1. Нотариатч дараахь тохиолдолд нотариатын үйлдэл хийхээс татгалзана:

1/ үйлчлүүлэгчийн бичиг баримт нь хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд харшилж байвал;

2/ нотариатчийн өөртэй нь болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр сүүхэдтэй нь холбоотой асуудал байвал;

3/ өөрийн нь байнгын үйлчлүүлэгчийн хувийн нууцтай холбоотой асуудлаар бусад этгээд үйлдэл хийлгэхийг хүсвэл;

4/ үйлчлүүлэгч нь эрх зүйн чадамжгүй буюу төлөөлөх эрхгүй байвал;

5/ хууль тогтоомжид заасан бусад үндэслэл байвал.

2. Нотариатч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлээр нотариатын үйлдэл хийхээс татгалзах эрхгүй.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчиж хийсэн нотариатын үйлдлийг хүчингүйд тооцох асуудлыг нотариатчийн буюу сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх шийдвэрлэнэ.

### **33 дугаар зүйл. Орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулах**

1. Үйлчлүүлэгч нь хэлгүй, дүлий, ярьж чаддаггүй буюу монгол хэл гэдэхгүй бол нотариатын үйлдэл хийх, бичиг баримт үйлдэхдээ тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч болон орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулна. Үйлчлүүлэгч нь орчуулагч /хэлмэрч/-ийг өөрөө сонгоно.

2. Орчуулагч /хэлмэрч/ нь зориуд худал орчуулбал /хэлмэрчилбэл/ ууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**34 дүгээр зүйл. Гэрч оролцуулах**

1. Үйлчлүүлэгч нь хараагүй, бичиг үсэг мэдэхгүй, түүнчлэн эрх зүйн чадамжгүй этгээд байвал нотариатын үйлдэл хийх, бичиг баримт үйлдэхдээ тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч болон нотариатч шаардлагатай гэж үзвэл гэрч оролцуулна. Энэ тохиолдолд дор дурдсан хүмүүсийг гэрчээр оролцуулж болохгүй:

1/тухайн нотариатчийн байнгын үйлчлүүлэгч;

2/насанд хүрээгүй;

3/эрх зүйн чадамжгүй этгээд;

4/бичиг үсэг мэддэггүй;

5/монгол хэл мэддэггүй.

2. Үйлчлүүлэгч хүсвэл нотариатын үйлдэл хийхэд гэрч оролцуулж болно.

**35 дугаар зүйл. Нотариатын үйлдэл хийсэн тухай тэмдэглэл, түүний агуулга**

1. Энэ хуулийн 33, 34 дүгээр зүйлд заасан үйлчлүүлэгч, бусад оролцогч оролцож байгаа бол нотариатын үйлдэл хийхэд тэмдэглэл хөтөлнө.

2. Тэмдэглэлд үйлчлүүлэгч, түүний хууль ёсны төлөөлөгч болон бусад оролцогчдын овог, нэр, нас, мэргэжил, хаяг, тэдгээрийн тайлбар, түүнчлэн гэрч, орчуулагч /хэлмэрч/-ийг оролцуулсан үндэслэл, холбогдох бичиг баримтыг танилцуулсан арга хэлбэр, үйл ажиллагааны үр дүн, дэс дараалал, нотариатчийн албан тушаал, нэр, бичиг баримтыг үйлдсэн газар, он, сар, өдрийг тодорхой бичнэ.

**36 дугаар зүйл. Тэмдэглэл үйлдэх арга, журам**

1. Тэмдэглэл нь гаргацтай, утга агуулгын хувьд ойлгомжтой, үг үсгийн засвар, оруулгагүй байх бөгөөд түүнд оролцогчдын нэр, хаяг, оршин суугаа газрыг товчлолгүйгээр тодорхой бичсэн байна.

2. Тэмдэглэл үйлдсэний дараа үйлчлүүлэгч болон оролцогчид уншиж сонсоно. Орчуулагч /хэлмэрч/ оролцож байгаа бол уг зүйлийг нэг бүрчлэн орчуулж /хэлмэрчилж/, материалтай танилцахад туслана.

3. Тэмдэглэлд үйлчлүүлэгч болон оролцогчид гарын үсэг зурж, нотариатч тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

4. Гарын үсэг зурж чадаагүй хүмүүс оролцож байгаа бол энэ тухай тайлбар бичнэ.

5. Тэмдэглэл нь 2 буюу түүнээс дээш хуудастай бол хуудас болгон дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд 2 дахь хуудаснаас эхлэн "2" гэж араб тоогоор дугаарлан үднэ.

**37 дугаар зүйл. Тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт хийх**

1. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр тэмдэглэлд утга агуулгыг нь өөрчлөхгүйгээр нэмэлт, өөрчлөлт хийж болно. Нэмэлт, өөрчлөлт

ийсний дараа үйлчлүүлэгч болон оролцогчид гарын үсэг зурж, нотариатч тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчиж хийсэн нэмэлт, өөрчлөлт хүчингүйд тооцогдоно.

### **38 дугаар зүйл. Үрэгдүүлсэн материалыг нөхөн бүрдүүлэх**

Нотариатч өөрт үлдсэн материалыг үрэгдүүлсэн бол үйлчлүүлэгчид өгсөн хувиас хуулбар хийж авна. Хуулбар дээр энэ тухай эмдэглэж, Нотариатчдын танхимын салбарт мэдэгдэн, бичиг баримт хадгалах журмын дагуу хадгална.

### **39 дүгээр зүйл. Үлдсэн материалыг шалгах**

1. Үйлчлүүлэгч буюу түүний эрх залгамжлагч, итгэмжлэгдсэн тгээдийн хүсэлтээр гэрчлэх бичиг баримтад холбогдох бусад үндсэн материалыг шалгаж болно.

2. Тухайн иргэн, хуулийн этгээдэд холбогдолгүй асуудлаар үндсэн материалыг шалгахгүй.

### **40 дүгээр зүйл. Бичиг баримтын хуулбар хийх**

Үйлчлүүлэгч нь гэрчлүүлсэн бичиг баримтаа үрэгдүүлбэл нотариатч үлдсэн хувиас хуулбар хийж өгнө.

### **41 дүгээр зүйл. Бичиг баримтыг хадгалах, үдэх**

1. Нотариатын үйлдэл хийхдээ үндэслэл болгосон материалыг, эрчилсэн бичиг баримтын хамт, олгосон дугаарын дагуу үдэж хадгална.

2. Шаардлагатай гэж үзвэл гэрчилж байгаа бичиг баримттай элбсөотой зүйлийг гэрэл зураг, бусад бололцоотой аргаар бэхжүүлэн эч хадгална.

3. Дугаарлан үдсэн материалыг зохих журмын дагуу архивт шилжүүлж байна.

## **Тавдугаар бүлэг**

### **Бусад зүйл**

### **42 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаанд тавих хяналт**

1. Хууль зүйн яам нь нотариатын үйл ажиллагаанд хяналт тавина.

2. Нотариатчдын танхим нь салбарынхаа үйл ажиллагаанд хяналт тавина.

3. Нотариатчдын танхимын салбар нь харьяа нутаг дэвсгэр дээрээ киллаж байгаа Нотариатчдын товчоо, нотариатчийн үйл ажиллагаанд хяналт тавина.

### **43 дугаар зүйл. Нотариатын бичиг баримтыг шалгах**

Нотариатын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрх хий байгууллага нь нотариатын бичиг баримтад шалгалт хийх

бөгөөд шаардлагатай бол холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж болно.

#### **44 дүгээр зүйл. Сахилгын шийтгэл, түүний төрөл**

1. Энэ хуулиар тогтоосон журам, нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн нь захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нотариатчид сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

2. Нотариатчид дараахь сахилгын шийтгэл ногдуулна:

1/сануулах;

2/нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан шийтгэлийг Сахилгын зөвлөл, 2-т заасан шийтгэлийг Сахилгын зөвлөлийн саналын дагуу Хууль зүйн сайд ногдуулна.

4. Нотариатчдын танхимын дэргэд 5-7 хүний бүрэлдэхүүнтэй Сахилгын зөвлөл ажиллана. Сахилгын зөвлөлийн дүрмийг Хууль зүйн сайд батална.

5. Сахилгын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Хууль зүйн сайдад, түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргаж болно.

6. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан, дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтан нотариатын үүрэг гүйцэтгэх явцдаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил гаргасан бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

#### **45 дугаар зүйл. Захиргааны хариуцлага**

1. Нотариатын тухай хууль тогтоомж зөрчсөн нотариатчид түүний гэм буруу, зөрчлийн шинж байдлыг харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

1/нотариатын үйлдлийг буруу хийсний улмаас үйлчлүүлэгчид хохирол учруулсан бол нотариатчийг 20000-40000 хүртэл төгрөгөөр торгох;

2/нотариатын үйлдэл хийж болохгүй нөхцөл байдлыг нуун дарагдуулж нотариатын үйлдэл хийсэн бол нотариатчийг 25000-50000 хүртэл төгрөгөөр торгох.

2. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан, дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтан нь нотариатын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа алдаа гарган үйлчлүүлэгчид хохирол учруулсан бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3. Нотариатын үйл ажиллагааны нууцыг задруулсан бол гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4. Нотариатын үйл ажиллагааг зохих зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар эрхэлсэн бол шүүгч олсон орлогыг хурааж, гэм буруутай этгээдийг 35000-50000 хүртэл төгрөгөөр торгоно.

#### **46 дугаар зүйл. Материалын хариуцлага**

Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 44, 45 дугаар зүйлд заасан зөрчил гаргасан этгээд нь сахилгын, захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзахгүйгээр үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.

#### **47 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах этгээд**

Нотариатын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг хохирсон этгээд болон Нотариатчдын танхим, түүний салбар гаргах эрхтэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7 дугаар зүйл. Нотариатын үйлчилгээний хураамжийн хэмжээ

1. Нотариатын үйлчилгээ үзүүлэхэд дор дурдсан хэмжээний хураамж хураана:

1/эд хөрөнгийн бус, үнэлж болохгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 500 төгрөг;

2/эд хөрөнгийн бус, үнэлж болохгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 500 төгрөг;

3/эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, хэлцэл гэрчлэхэд 750 төгрөг;

4/хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичиг гэрчлэхэд 2000 төгрөг;

5/хуулийн этгээд үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 500 төгрөг;

- 6/итгэмжлэл гэрчлэхэд 500 төгрөг;  
 7/бичиг баримтыг гэрчлэхэд хуудас тутмаас 50 төгрөг;  
 8/орчуулсан бичиг баримтыг гэрчлэхэд хуудас тутмаас 100 төгрөг;  
 9/бичиг баримтад зурсан гарын үсгийг гэрчлэхэд 1000 төгрөг;  
 10/гэрчлэгдсэн бичиг баримтын хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 50 төгрөг;  
 11/үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 2000 төгрөг;  
 12/өв залгамжлах эрх, гэрээслэлийг гэрчлэхэд 500 төгрөг;  
 13/гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 250 төгрөг;  
 14/үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой бичиг баримт гэрчлэхэд 2000 төгрөг;  
 15/өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхээс бусад хүмүүст өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 4000 төгрөг;  
 16/үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхэд гэрээний үнийн дүнгээс 0,03 хувь, бусад хүмүүст 0,05 хувь;  
 17/энэ хэсгийн 1,2,3,16-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 сая хүртэл төгрөгөөс 0,02 хувь, 1 сая төгрөгөөс давсан хэсгээс 0,01 хувь.
- 2.Хураамжийг гэрээ, хэлцэлд өөрөөр заагаагүй бол хэлэлцэн тохирогч талууд тэнцүү хувааж төлнө.
- 2 дугаар зүйл.Энэ хуулийг Нотариатын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "нотариатад хадгалуулах ба нотариат" гэснийг "банкны хадгалах газарт хадгалуулсныг нотариатч гэрчилж" гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн "нотариатад хадгалуулсныг" гэснийг "банкны хадгалах газарт хадгалуулсныг нотариатч гэрчилснийг" гэж, 407 дугаар

үйлийн 1 дэх хэсгийн "баг, сумын Засаг даргаар" гэснийг "сум, үүргийн Засаг даргын тамгын газрын тусгайлан зөвшөөрөл авсан жилтнаар" гэж, 412 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 415 дугаар үйлийн 1 дэх хэсгийн "баг, сумын Засаг даргад" гэснийг "сум, үүргийн Засаг даргын тамгын газрын тусгайлан зөвшөөрөл авсан жилтанд" гэж, 421 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "баг, сумын Засаг арга" гэснийг "сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын усгайлан зөвшөөрөл авсан ажилтан" гэж, мөн хэсгийн "хамгаалах рга хэмжээ авна" гэснийг "хамгаалуулахаар зохих, байгууллагад гэдэгдэнэ" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай хууль хүчин өгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд дор дурасан агуулгатай 177<sup>3</sup> дугаар үйл нэмсүгэй:

"177<sup>3</sup> дугаар зүйл. Нотариатын тухай хууль тогтоомж зөрчих

1. Нотариатын тухай хууль тогтоомж зөрчиж иргэн, хуулийн тээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан бол ёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун тавин мянгаас ёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийн улмаас их хэмжээний хохирол учирсан, эсхүл втан үйлдсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нотариатын тухай хууль хүчин гөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАРЛИГ, ХУУЛИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. "БНМАУ-ын Улсын Нотариатын хуулийг батлах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 85 дугаар зарлиг, "Хууль, хуулийн заалт, зарлиг хүчингүй болсонд тооцох, өөрчлөх тухай" 1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн хуулийн 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нотариатын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 1-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН  
ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай 1996 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйл дэх экспортын гаалийн татварын хэмжээ хаягдал хар төмөр, ширэмд "17 төгрөг" гэснийг "140 төгрөг", хаягдал хөнгөн цагаанд "128 төгрөг" гэснийг "350 төгрөг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэхүү хуулийг 1997 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 12 дугаар зүйлийг дараахь байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Аж ахуйн нэгж, байгууллага нь тайлан тэнцлээ оны эхнээс өссөн дүнгээр улирал бүр гаргана. Санхүүгийн тайлан нь татварын алба, хувьцаа эзэмшигч болон хувь нийлүүлэгчидтэй тооцоо хийх үндэслэл болно. Зөвхөн баталгаажуулсан санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт хэвлэн нийтэлж болно"

2/8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Сангийн сайдын дэргэд Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөл ажиллана."

3/12 дугаар зүйл:

"12 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх, албан тушаалтныг 60000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацааг зөрчсөн бол хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч буруутай этгээдийг 50000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3. Санхүүгийн тайлангаа 4 улирал дараалан гаргаагүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоож, улсын бүртгэлийн гэрчилгээ, тэмдгийг хураана.

4. Мэргэшсэн нягтлан бодогч нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл хөглөх, шалгах үйл ажиллагаандаа алдаа гаргасан, эсхүл буруу гаргасан тайлан тэнцлийг баталгаажуулсан бол мэргэшсэн нягтлан бодогчийнх нь эрхийг хасах буюу түүнд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ."

2 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "орон сууцны талбайн хөлсний болон хувийн харилцуур утасны /үүрэн харилцуур утаснаас бусад/ төлбөрийн 50 хувь," гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "5 дахь хэсэг" гэснийг өмнө "4," гэж; мөн хэсгийн "хэсэгт зааснаар" гэснийг дараг "сонгуульд оролцсон" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг дог дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.Нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийг Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсэгт заасан журмын дагуу хэлэлцэж батална."

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР,  
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС  
ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ,  
ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ  
ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай", "Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай", "Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай" хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн "1997 оны 6 дугаар сарын 1-ний өдөр" гэснийг 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 1997 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДСОН  
ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн гушин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хуралдааны дэгийн хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Нацагийн Багабандийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЦУГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН  
ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. "Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай" хуульд дараахь зүйл шинээр нэмсүгэй:

"2 дугаар зүйл. Мал аж ахуйн гаралтай зарим түүхий элдэ дор дурдсан хэмжээгээр экспортын гаалийн татвар ногдуулсугай:

д/д	Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
1	Ямааны боловсруулаагүй ноолуур	кг	4000
2	Тэмээний боловсруулаагүй ноос /эм/	кг	200
3	Тэмээний боловсруулаагүй ноос /эр/	кг	100

2 дугаар зүйл Энэ хуулийг 1997 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн туха хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингү болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэ хууль зөрчиж байна гэж үзсэн иргэн Ж.Бямбадорж, Д.Төмөртого нарын гомдлыг хянан шийдвэртэсэн Үндсэн хуулийн цэцийн 196 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн О2 тоот дүгнэлтийг хэлэлцээ Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн туха хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжий сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулт тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох туха хуулиудыг хэрэглэх журмын тухай 1997 оны 1 дүгээр сарын 16-н өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 3-т заасан "тэтгэврийн эрх н хэрэгжиж байгаа төрийн албан хаагч, хөдөлмөрийн гэрээгээ ажиллагч"-дын тэтгэврийг зогсоох гэсэн заалт, Нийгмийн даатгалы сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай 1994 оны 6 дугаар сары 7-ны өдрийн хуулийн 4<sup>1</sup> зүйлийн "тэтгэвэр авах эрх үүсэх үед болс үүссэнээс хойш төрийн албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдсө хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч уг гэрээгээ дуусгавар болгосс нөхцөлд даатгуулагчийн тэтгэвэр авах эрх нь хэрэгжинэ" гэсэн заа нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтуудыг зөрчсө байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 1997 оны 4 дүгээр сарын 9-н өдрийн О2 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй хө богдуулан зохих хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулий төсөл боловсруулж, 1997 оны 5 дугаар сарын 15-ны дотор багтаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан т даалгасугай.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр илийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын даргын 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 59 дүгээр захирамжийг хүчингүй болгох тухай Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн гишүүдээс ирүүлсэн тогтоолын эсргийг хэлэлцээд Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан хянуулах чиг үүргийнхээ дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргасан байна гэж үзэж уг тогтоолын төслийг санаачлагчид нь цаасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын 1993 оны 59 дүгээр тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

**1 дүгээр зүйл.** "Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь хэсгийн 5 дахь заалтын нэрийг "МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ" гэсний дараа "1 дүгээр" гэж, мөн хавсралтын 2 дахь заалт дор дурдсан агуулгатай 7 дахь заалт тус тус нэмсүгэй:

\*7. Сэлэнгэ аймаг дахь  
сум дундын 2 дугаар  
прокурорын газар

Хөтөл

Хөтөл, Сайхан, Орхонтуул,  
Орхон, Баруунбүрэн,  
Сант\*

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүний  
өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг  
батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүний өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүний өмсгөлийг 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэглэхээр тогтоосугай.

3. Энэ тогтоолыг Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1997 оны  
оны 32 дугаар тогтоолын хавсралт

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ӨМСГӨЛИЙН ЗАГВАР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

### Нэг.Гишүүний өмсгөлийн загвар

1.Үндсэн хуулийн цэцийн гишүүний өмсгөл /цаашид "өмсгөл" / нь Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат биш, бие даасан цэцгийн бэлэгдэл, Үндсэн хуулийн цэцийн нэр төр, ёс зүйн болон цэцийн хуралдааны төр ёсны хүндэтгэлийн илэрхийлэл мөн.

2.Гишүүний өмсгөл нь Монгол төрийн уламжлалт өнгө, лолын онцлог, дэлхийн улс орны Үндсэн хуулийн цэцийн зүүдийн хуралдааны өмсгөлийн нийтлэг жишигт үндэслэн, гол үндэсний хувцасны шинжийг тусгасан хүрэн өнгөтэй байна.

3.Гишүүний өмсгөл нь сул чөлөөтэй хэлбэртэй, босоо захтай, эр нь уулзсан, хүрэн өнгийн торгомсог эдээр хийсэн зангидмал ван товчтой, зах, энгэр, барта, ханцуйны ирмэгүүд хар өнгийн гомсог эдээр эмжсэн дотортой байна.

4.Гишүүний өмсгөлийн хоёр мөрний оёдлын энгэр талд нугалаас гаж хувцсыг өргөн чөлөөтэй болгохын хамт ханцуй нь үзүүр гээ өргөн /трапец/ хэлбэртэй байна.

5.Гишүүний өмсгөлийн бүрэлдэхүүн хэсэг нь малгай юм. лгайн их бие хүрэн өнгөтэй байх бөгөөд орой дээрээ ижил ийн сампинтай, ар шилээ хүртэл эргэн тойрон дэрэвгэр хар ийн эргүүлэгтэй, ардаа хос улаан залаатай байна.

5.Өмсгөлийн загварын зургийг хавсаргав.

### Хоёр.Гишүүний өмсгөлийг хэрэглэх журам

1.Гишүүний өмсгөлийг зөвхөн Цэцийн хуралдааны үед өмсөнө.

2.Гишүүн өмсгөлдөө гүн хүндэтгэлтэй хандаж, цэвэр үзэмжтэй лгаж хэрэглэнэ.

3.Гишүүний өмсгөлийн эдэлгээний хугацаа дуусаагүй байхад дүүлсэн, гэмтээсэн тохиолдолд түүний эдэлгээний эзэгдийг зан үнийг буруутай этгээдээр төлүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурла ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 1997 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Долоо хоногийн ажлын цагийг ажлын өдөрт шилжүүлэх тухай”, “Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлө оруулах тухай” хуулийн төслүүдийн эдийн засгийн судалгаа, тооц үндэслэл хангалтгүй, Хөдөлмөрийн хууль болон Төрийн албан тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудтай уялдуул шаардлагатай тул уг төслүүдийг дахин боловсруулахаар хуу санаачлагчид буцаасугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж Улс Их Хурлын 1997 оны намрын чуулганд хэлэлцүүлэхээр бэлтг хуулийн төслийг өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан, даалгасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурла ТОГТООХ нь:

1. Засгийн газраас 1997 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улс Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын тухай хуу нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн даатгалын санг олгох үйлдвэрлэлийн өсөл, мэргэжлээс шалтгаалсан өвч тэтгэвэр, тэтгэмж, талбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчл

уулах тухай", "Хуулийн заалт хүчингүй болсонд тооцох тухай" улийн төслүүдийг Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хай хуультай уялдуулах, үйлдвэртэлийн осол, мэргэжлээс алтгаалсан өвчний даатгалд ажил олгогч /улсын байгууллага/-оос лөх шимтгэлийн дээд хэмжээ нэмэгдсэн үед улсын төвлөрсөн сөвт хэрхэн нөлөөлөх, хөдөлмөрийн хэвийн бус, онцлог ажил иргэжлийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн өндөр сны тэтгэврийн эрх хэрэгжих нөхцлийг тодорхойлох зэрэг ардлагад нийцүүлэх, мөн Засгийн газрын 1996 оны 19 дүгээр тоолоор улсын хэмжээнд явагдаж буй ажлын нөхцөл, аюулгүй ажиллагааны үзлэгийн дүнг харгалзан үзэх шаардлагын үүднээс гээр хуулийн төслүүдийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид буцаасугай.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаж, хуулийн слүүдийн бичлэгийн техник, боловсруулалтыг сайжруулан Улсын Хурлын 1997 оны намрын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн цүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар  
хот

#### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр элийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ИГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 1997 оны 5 дугаар сарын 6-ны өр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Хүн амын амьжиргааны од түвшингийн тухай" хуулийн төсөлд хүн амын амьжиргааны галгаажих доод түвшингийн талархи үзэл баримтлал бүрэн тус-даагүй байна гэж үзэж уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан шаардлага хангасан хуулийн слийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн кр /М.Энхсайхан/-т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийг товлох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нацагийн Багабандийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийн товыг 1997 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 1 цаг 30 минутад байхаар тогтоосугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Сумын төв шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн Сэлэнг аймгийн Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хууль заасан ирцийн бүрэлдэхүүнтэй хуралдаж чадаагүй байх тул Монго Улсын Засгийн газраас 1997 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Сумын төв шилжүүлэх тухай тогтоолын төслийг Засгийн газарт буцаасугай."

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 4 дүгээр  
сарын 16-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

**БНПУ-ын зарим иргэнийг "Найрамдал"  
медалиар шагнах тухай**

Монгол Улс, БНПУ-ын хоорондын харилцааг шинэ нөхцөл  
йдалд өрнүүлэн хөгжүүлэх, манай орныг сурталчлахад оруулж  
йгаа хувь нэмрийг нь үнэлж БНПУ-ын Сеймийн гишүүн,  
эймийн Польш-Монголын Парламентийн бүлгийн дарга хатагтай  
абэла Яруга Новацка, БНПУ-ын Шинжлэх ухааны академийн  
саатны зүйн хүрээлэнгийн ажилтан монгол судлаач Славой  
ынкевич, Варшав хотын Ази-Номхон далайн музейн дарга Анджей  
вжыняк нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасуугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар  
хот

**Н.Өлзийд Монгол Улсын гавьяат  
багш цол олгох тухай**

Боловсролын байгууллагад багш, удирдах ажилтнаар 30 гаруй жил  
бүтээлтэй ажиллаж заах аргын шинэлэг хэлбэрүүдийг бүтээлчээр  
рөгжүүлэн сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлснээр шавь нар  
улсын болон олон улсын математикийн олимпиадад амжилттай  
олцсон хийгээд захирлаар ажиллах хугацаандаа сургалт хүмүүж-  
йн ажлыг нийгмийн амьдралын шинэ нөхцөл, шаардлагад  
йцүүлэн төсөл шалгаруулан хэрэгжүүлж, сургалтын чанар, үр дүнг  
эшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дундговь  
мгийн Мандалговь сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн  
сирал Намжилын Өлзийд Монгол Улсын гавьяат багш цол  
госугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар  
хот

**Х.Шаравт Монгол Улсын хүний  
гавьяат эмч цол олгох тухай**

Эрүүл мэндийн салбарт 30 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин, бүтээлч санаачилга гаргаж эмчилгээний шинэ аргуудыг практикт амжилттай нэвтрүүлэх хагалгааны дараахь хүндрэлийг тогтмол бууруулж олон мянган хүнийг мэс заслын аргаар эмчлэн амийг нь аврах зэргээр хөдөө орон нутагт мэс заслын эмчилгээг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч их эмч Хоролын Шаравт Монгол Улсын хүний гавьяат эмч цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 5 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар  
хот

**Сайто Жюро, Сүзүки Мүнэо,  
Цунэо Икэда нарыг олон,  
медалиар шагнах тухай**

Монгол Улс, Япон улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Японы парламентын Зөвлөхүүдийн танхимын дарга Сайто Жюро, Төлөөлөгчдийн танхимын гишүүн Сүзүки Мүнэо нарыг "Алтан гадас" одонгоор, Кобүнша компанийн ерөнхийлөгч Цунэо Икэдаг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 77

Улаанбаатар  
хот

### Комисс томилох тухай

1. Монгол Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд  
ын Зөвлөлийн дарга, Улсыг батлан хамгаалах зөвлөлийн дарга  
н Жамбын Батмөнхийн шарилыг оршуулах ажил эрхлэн зохион  
гуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:

Ц.Элбэгдорж

-Улсын Их Хурлын дэд дарга

Комиссын орлогч дарга:

Д.Дорангжав

-Батлан хамгаалахын сайд

Нарийн бичгийн дарга:

Г.Лхагваа

-Засгийн газрын Хэрэг эрхлэх  
газрын дарга

Гиншүүдэд:

1.Лхагважав

-Гэгээрлийн сайд

2.Чимид

-Ерөнхийлөгчийн Тамгын газрын  
дарга

А.Зангад

-Эрүүд мэнд, нийгмийн хамгааллын  
яамны төрийн нарийн бичгийн дарга

Г.Батжаргал

-Төрийн ёслолын албаны дарга

Г.Баатар

-Увс аймгийн Засаг дарга

Г.Ганцог

-МУИС-ийн ректор

Г.Жамьянсэнгээ

-Улаанбаатар хотын цагдаагийн  
газрын дарга

2. Ж.Батмөнхийн шарилыг оршуулах ажлыг төрийн ёслолын  
мын дагуу зохион байгуулахыг комисст үүрэг болгосугай.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар  
хот

**Б.Ширэндэвт Монгол Улсын  
Хөдөлмөрийн баатар цол  
олгох тухай**

Монгол Улсад шинжлэх ухаан, боловсрол, соёлыг хөгжүүлэх үйлсэд олон жил хүчин зүтгэж, дээд боловсролын тогтолцоог бүрдүүлэх, орчин үеийн шинжлэх ухааны байгууллагын үндсийг тавьж төлөвшүүлэн бэхжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсныг нь үнэлж Академич Базарын Ширэндэвт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын олон, "Алтан соёмбо" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар  
хот

**Ш.Пүрэвжавт Монгол Улсын гавьяат  
багш цол олгох тухай**

Ардын боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллахдаа хөдөлмөрийн өргөтгөсөн сургалтыг санаачлан зохион байгуулж үйлдвэрлэл сургалтын материаллаг баазыг өргөжүүлэн цахилгаан хөрөө, харуул, зорогч хутга, хивс нэхэгч зэрэг хөдөлмөрийн олон багаж хэрэгслийг хийж ашиглан дархан, мужааны болон лингафонь кабинет байгуулж ахлах ангийн 700 гаруй сурагчдад хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгон амжилттай сургахын зэрэгцээ залуу багш нарыг сургаж дадлагажуулахад дорвитой хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Сургууль дундын сургалт үйлдвэрлэлийн төвийн багш Шагдарын Пүрэвжавт Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 81

Улаанбаатар  
хот

**Зарим шүүхийн шүүгч, ерөнхий  
шүүгчийг албан тушаалаас  
чөлөөлөх тухай**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дандамбын эндовыг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, цонгийн Цогтзанданг Завхан аймгийн шүүхийн шүүгчийн, ачагдоржийн Төмөрбаатарыг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчийн, Рэнцэндоржийн Үйтүмэнг Орхон аймгийн шүүхийн шүүгчийн, Бандийн Одонцэцэгийг Ховд аймаг дахь сум дундын 2 гаар шүүхийн ерөнхий шүүгчийн, Шагдарын Энхмааг Өмнөговь маг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, ахгалын Найданг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Оросоогийн Нарангэрэлийг Завхан аймаг дахь сум ндын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Чойжилсүрэнгийн Луунбаатарыг Сүхбаатар аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Лүүрэвийн Жавзмааг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Түдэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймаг дахь сум ндын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Янжонгийн Бадамсүрэнг Янхонгор аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, нсамбуугийн Цэнгэлийг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Раднаагийн Бисъяаг Дундговь аймаг дахь сум дундын дүхийн шүүгчийн, Замбын Минсжирмааг Увс аймаг дахь сум ндын шүүхийн шүүгчийн, Цэсэнжавын Алтанцолыг Нийслэлийн Улаанбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус лөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар  
хот

### Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Чүлтэмийн Сүрэнжавыг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчээр, Оросоогийн Нарангэрэлийг Завхан аймгийн шүүхийн шүүгчээр, Түдэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчээр, Лүүрэвийн Жавзмааг Увс аймгийн шүүхийн шүүгчээр, Ёндонгийн Цогтзандан Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Зундуйн Хосбаярыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Цэдэн Ишийн Нэргүйг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчээр, Дамдинсүрэнгийн Ганчимэг, Лхагвын Энхтайвас Дамдинжавын Мөнхцэцэг нарыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын дүгээр шүүхийн шүүгчээр, Банзрагчийн Сайнбаярыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчээр, Дагвадоржийн Буянжаргалыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчээр, Чойжилсүрэнгийн Чулуунбаатар, Тогмидын Мөнхтуя нарыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Миймаагийн Батсүхийг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Хаянхирваагийн Оюунжаргалыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Бүжинлхамын Нямсүрэнг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1997 оны 5 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар  
хот

### Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Чүлтэмийн Сүрэнжавыг Говьсүмбэр аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр

ндонгийн Цогтзанданг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр, Данзангийн Эрдэнэбилэгийг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр, Бэгзийн Дамбыг Сонд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 6 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий  
штабын дүрмийг батлах тухай**

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн "Монгол Улсын зэвсэгт хүчний Ерөнхий штабын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**П.ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
1997 оны 111 дүгээр зарлигийн  
хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ  
ЕРӨНХИЙ ШТАБЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий штаб нь Зэвсэгт хүчин, бусад цэргийн удирдлагын төв байгууллага мөн.
2. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үйл ажиллагааны үндсэн зарлого нь Зэвсэгт хүчин, бусад цэргийг дайнд ашиглах болон цэргийн дайчилгаа явуулах төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хийн байгуулах, Зэвсэгт хүчин, бусад цэргийг цэргийн мэргэжлийн нэгдэлээр хөгжлэх, Зэвсэгт хүчний дайчилгааныг ба байлдааны болон

байдал, сургалт бэлтгэл, соёл хүмүүжлийн ажил, бүх төрлийн хангалт, цэргийн албыг зохион байгуулан удирдах явдал мөн.

3. Зэвсэгт хүчний Ерөнхий штабыг зохих журмын дагуу Монго Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон дарга гэргүүн; Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга Зэвсэгт хүчний Ерөнхи командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлагын дор ажиллана.

4. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын тайван ба байдлааны цагийг зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлан хамгаалах асууда эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб нь үйл ажиллагаагаа Монго Улсын хууль тогтоомж, цэргийн дүрэм, Зэвсэгт хүчний Ерөнхи командлагч, батлан хамгаалахын сайдын зарлиг, удирдамж тушаалын хүрээнд явуулж, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Батлан хамгаалахын сайд нарт ажлаа тайлагнана.

6. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын даргын дэргэд түүнд зөвлө эрхтэй зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга батална.

Тайван цагт Зэвсэгт хүчин, бусад цэргийн хамтын боло харилцан ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэхэд зөвлөлий хуралдаанд бусад цэргийн штабын дарга, холбогдох албан тушаалта нарыг оролцуулж болно.

7. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб зохих журмын дагуу тамг тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

#### Хоёр. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын үүрэг, эрх

8. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб дараахь үүргийг хүлээнэ:

1/олон улсын болон бүс нутгийн цэрэг-улс төр, цэрэг-стратегий байдалыг байнга судлан дүгнэлт хийж, төрийн дээд болон Зэвсэгт хүчний удирдлагыг зохих мэдээллээр хангахад оролцох;

2/төрийн цэргийн бодлогыг боловсруулахад оролцож Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болго зэвсэглэмжийг сайжруулах, бэлэн байдал, байлдааны чадварыг өндөржүүлэхарга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;

3/Монгол Улсын Их Хурлын тогтоосон бие бүрэлдэхүүний тоон хязгарлалтын хүрээнд Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын тайл цагийн орон тоо, тэдгээрийн байршил, Зэвсэгт хүчин, бусад цэргий байлдааны цагийн орон тооны асуудлаар санал боловсруулах. Зэвсэгт хүчин, бусад цэргийн анги байгууллагуудын байлдааны томилго бүс, чиглэл, үүргийг тодорхойлох;

4/Зэвсэгт хүчин, бусад цэргийг дайнд ашиглах сэрэмж төлөвлөгөө, дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, байлдаан бэлэн байдлын зохиц эрэгт шилжүүдэх, улсын хил халхлах, цэргийн

ийдааны ажиллагааны бүсэд гаргаж хүч задлах, операци, байланыг бэлтгэж явуулах, тагнуул-хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх лөвдөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

5/Зэвсэгт хүчин, бусад цэрэг болон төрөл, мэргэжлийн цэрэг, дгээрийн штабуудын харилцан ажиллагааг зохион байгуулах;

6/хилийн цагийн байдалд тогтмол дүнгэлт хийж байх. Хууль-гтоомжийн дагуу гадаадын нисэх хэрэгслийн нислэгийн байдалд ргийн мэргэжлийн хяналт тавих, агаарын хилийн хамгаалалтыг хион байгуулах;

7/ Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны жижүүрлэлтийн ринмыг тогтоож, гүйцэтгэлд хяналт тавих;

8/цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн судалгаа, нэгдсэн тоо-ог хөтөлд, Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар дэлгэн байгуулах болон йны үел шаардагдах хүн хүч, зэвсэг техник, галт хэрэгсэл, гахуун, бусад нөөцийн хэмжээ, байршил, бүрдүүлэх аргыг тогтоох ал боловсруулах;

9/батлан хамгаалах эрх ашгийн үүднээс нутаг дэвсгэрийн судалгаа уулж, түүнийг төхөөрөмжлөх асуудлаар санал боловсруулах, цэрэг-матегийн ач холбогдолтой объектыг байгуулах, байршлыг тогтоох аар мэргэжлийн дүнгэлт гаргах;

10/Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүн болон дайчилгааны тгэл нөөцийг сургалт, штабуудын бэлтгэлийн чиглэл, арга хэл-ийг тодорхойлж, тэдгээрийг төлөвлөж, мэргэжлийн удирдлагаар гах, хяналт тавих, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бие бэлдэр, тэл зүй, ёс суртахууны өндөр түвшинг хангах, тэдэгтэй зохиох л хүмүүжлийн ажлын агуулга, үндсэн чиглэлийг тодорхойлох, налт, соёл хүмүүжлийн ажлын материаллаг баазыг бэхжүүлэх, нэ техник хэрэгслээр хангах асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх;

11/Зэвсэгт хүчний анги байгууллагуудад цэргийн албыг зохион гуулан удирдаж, Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нараг, дүрэм, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Ерөнхий абын даргын тушаалын биелэлтэд хяналт тавих;

12/Зэвсэгт хүчний удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох ыг төлөвлөж хэрэгжүүлэх, Цэргийн холбоо, удирдлагын автомат-үлсан системийн найдвартай байдлыг хангах техник, технологийн цлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;

13/Зэвсэгсэл, техникийн бэлэн байдлыг хангаж, тэдгээрийн аглалт, хадгалалт, засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн хангалтыг өвлөж удирдах, зохион байгуулах. Зэвсэгт хүчнийг шонг эгсгэл, техникээр хангах санал боловсруулах;

14/Зэвсэгт хүчний ар талын бүх төрлийн материал, хэрэгслийн галтыг төлөвлөх, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар гах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

15/Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн нууцны хадгалалт, цэргийн далдуур удирдлагын горимыг тогтоож, биелэлтэд нь хяналт тавих;

16/ Цэргийн боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлж, цэргийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлэх;

17/Цэргийн татлага, халалтыг зохион байгуулах;

18/Бүх цэргийн Их хар сүдний хадгалалт, хамгаалалт, үйлчилгээ, залж цэнгүүлэх, тахилга үйлдэх ажлыг зохион байгуулах. Цэргийн ангийн байлдааны туг, тамга тэмдгийг тогтоосон загварын дагуу үйлдүүлэх;

19/төрийн ёслолын цэргийн арга хэмжээг зохион байгуулж явуулах;

20/Зэвсэгт хүчний анги, байгууллагыг иргэний хамгаалалтын чиглэлээр томилгоожуулан бэлтгэж, байгалийн гамшиг, гэнэтний бусад аюултай тэмцэхэд тэдгээрийг ашиглах, ороцуулах ажлыг зохион байгуулах.

9. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб дараахь эрх эдэлнэ:

1/Зэвсэгт хүчний Ерөнхий штаб нь өөрийн чиг үүргийн асуудлаар Зэвсэгт хүчний төрөл цэрэг, бусад цэргийн штабууд, аймаг нийслэлийн цэрэг-иргэний хамгаалалтын байгууллагуудад тушаал үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, шаардлагатай тайлан мэдээллийг гаргуулан авах;

2/төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн нэгжид батлан хамгаалах асуудлаар бие дааж болон эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран шалган туслах, мэдээ судалгаа гаргуулж авах;

3/батлан хамгаалах зориулалтаар ашиглаж болох нисэх онгоцны буудал, төмөр зам, авто зам, гүүр, нөөцийн томоохон агуулах эмнэлэг, холбоо, үйлдвэр, засварын газар, цахилгаан станц зэрэг иргэний барилга байгууламж барих газрыг цэрэг-стратегийн үүднээс судалж, санал дүгнэлт гаргах;

4/цэргийн төлөвлөгөөг сургууль, дайчилгааны цугларалтын үед Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу холбоо, тээврийн болон шаардлагатай бусад хэрэгслийг дайчлан гаргуулах ажлыг зохион байгуулах;

5/үндсэн хөрөнгийн данснаас техник, зэвсэглэлийг хасах асуудлыг боловсруулж Батлан хамгаалахын сайдын зөвлөлд оруулах;

6/хорооны захирагчийн орлогч, түүнтэй адилтгах болон тэдгээрээ доошхи албан тушаалд офицер, ахлагч нарыг томилох, чөлөөлөд дээрх албан тушаалын цэргийн цол олгох, хасах. Боловсон хүчний сургаж бэлтгэх, удирдах албан тушаалд дэвшүүлэх, шагнаж урамшуулах талаар санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;

7/Зэвсэгт хүчний төсвийн төсөл боловсруулж Зэвсэгт хүчний мөнхий штабт хуваарилагдсан төсвийг өөрийн эрх үүргийн хүрээнд хиран зарцуулах;

8/Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бэлэн байдлыг шалган зварлах;

9/Батлан хамгаалахын сайдын зөвшөөрлөөр гадаад орнуудын өсөгт хүчний дээд штабуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах.

-----oOo-----



## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Гаябат
Гишүүд:	Б. Бадамханд Ч. Дашням Б. Цэндлоо Б. Чимд Б. Энэбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 6-р сарын 23-нд  
Өрөлтөд 1997 оны 6-р сарын 23-нд. Хэвлэлтэд  
1997 оны 7-р сарын 15-нд. Хэвлэлийн хуудас 4.75.  
Хэвлэсэн тоо 4458ш

Манай хаяг: Улаанбаатар-12  
Төрийн ордон. Утас 322838

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг  
Эрхлэх Газрын харьяа  
Хэвлэх үйлдвэр



